



АМЛАЛТААС ҮЙЛ ХЭРЭГ РҮҮ

ХҮНИЙ ЭРХИЙГ
МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН
ЗОРИЛТЫН ТӨВД ТАВЬЦГААЯ

ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ



Эмнести Интернэшнл нь 150 гаруй орны 3 сая гаруй хүний эрхийг хамгаалагчдыг нэгтгэсэн даян дэлхийн хөдөлгөөн юм. Бидний хүсэл бол Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал болон бусад олон улсын хүний эрхийн жишиг хэмжээнд заасан хүний эрх, эрх чөлөөг энэ дэлхийн хүн бүрт бүрэн эдлүүлэхэд оршино. Бид хүний эрх, эрх чөлөөг ноцтой зөрчих явдлыг таслан зогсоох зорилгоор судалгаа хийж кампанит ажил явуулдаг. Эмнести Интернэшнл нь аливаа засгийн газар, улс төрийн үзэл бодол, эдийн засаг болон шашны үзлээс ангид. Манай үйл ажиллагааны санхүүжилт ихэнхдээ гишүүдийн татвар, хандив, тусламжаас бүрддэг.

ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ



Эмнести Интернэшнлийн Хэвлэлийн Албанаас эрхлэн гаргав.

Хаяг:

Peter Benenson House

1 Easton Street

London WC1X 0DW

United Kingdom

www.amnesty.org

© Эмнести Интернэшнлийн Хэвлэл

Индекс: IOR/41/012/2010

Эх хэл: Англи

Хэвлэсэн: Эмнести Интернэшнлийн Олон Улсын

Нарийн Бичгийн Дарга Нарын Газар, Нэгдсэн Вант Улс

Бүх эрхийг хуулиар хамгаалсан. Энэ хэвлэл нь зохиогчийн эрхтэй. Нөлөөллийн ажил, кампанит ажил, сургалтын зорилгоор хөлс төлөхгүйгээр дахин хэвлэж олшруулах боломжтой боловч худалдахыг зөвшөөрөхгүй. Дээрх зорилгоор хэрэглэх нөхцөлд зохиогчийн эрхийг эзэмшигчид мэдэгдэхийг хүсч байна. Бусад шалтгаанаар хэвлэх олшруулах, хэвлэлд ашиглах, орчуулахыг хүсвэл хэвлэгчээс урьдчилан бичгээр зөвшөөрөл авах ба төлбөр төлж болзошгүй.

ГАРЧИГ

1 дүгээр бүлэг: Оршил.....	1
2 дугаар бүлэг: Хүний эрх ба Мянганы Хөгжлийн Зорилт.....	5
Бүгдийг хамруулах.....	6
Хяналт үнэлгээ хийх, тайлагнахад тулгарч буй асуудал.....	7
Ололт амжилтыг бодитоор үнэлэх механизм бий болгох нь.....	8
Дэлхийн түвшний зорилтын эргэн тойронд.....	9
Үндэсний зорилтууд.....	9
Шийдвэр гаргахад оролцох.....	10
Хариуцлага, алдааг залруулах асуудал	11
Үндэсний хариуцлагын механизм.....	12
Олон улсын хариуцлагын механизм.....	14
3 дугаар бүлэг: Мянганы хөгжлийн зорилтонд хүний эрх ямар хамааралтай вэ?.....	15
Хүний эрх болон хүйсийн тэгш байдал.....	15
Ялгаварлан гадуурхах, жендэрийн шинжтэй хүчирхийлэл, бусад саад бэрхшээл.....	16
Хүний эрхийн хэм хэмжээг хангах.....	18
Эхийн эрүүл мэнд ба хүний эрх.....	18
Зорилт, шалгуур үзүүлэлт.....	19
Бэлгийн болон нөхөн үржихүйн эрх.....	20
Төрөлтийн хүндрэлд нөлөө үзүүлж буй хүчин зүйлс.....	21
Оролцооны асуудал.....	22
Хүний эрхийн хэм хэмжээг хангах нь.....	23
Хүний эрх ба ядуурал.....	32
Дэлхийн түвшний зорилт.....	32
Өмчлөх эрхийн зөрчил.....	33
Идэвхитэй оролцоо.....	35

Хүний эрхийн хэм хэмжээг хангах нь.....	35
4 дүгээр бүлэг: Хүний эрх бол хөгжлийн үндэс.....	37
Засгийн газруудад өгөх зөвлөмж.....	38
Хариуцлагыг сайжруулах нь.....	38
Хүний эрхийн хэм хэмжээг хангах нь.....	38
Нийгмийн эмзэг бүлгийнхнийг хамруулах нь.....	39
Олон улсын хөгжлийн болон санхүүгийн байгууллагад өгөх зөвлөмж.....	39
Хөгжлийн туслалцаанд талуудын хүлээх үүрэг.....	40
2015 оноос хойш хийгдэх ажил.....	41
Мянганы Хөгжлийн Зорилт ба олон улсын гэрээ.....	43
Зүүлт.....	47

1 ДҮГЭЭР БҮЛЭГ: ОРШИЛ

“Бид амьдрах нөхцөлгүй, туйлын хүнд орчинд амьдарч буй хүмүүсийн төлөө, тэднийг ядуурал хоосролоос ангижруулахын тулд бүх хүч чадлаа дайчлан ажиллах болно... Үүний тулд ... гишүүн улс орнууддаа хүний иргэний, улс төрийн, эдийн засгийн, нийгэм соёлын эрхийг хангаж хамгаалахын төлөө тэмцэнэ.”

НҮБ-ын Мянганы тунхаглал, 2000 оны 9 дүгээр сар, 11, 25 параграф

10 жилийн жилийн өмнө НҮБ-ын гишүүн улс орнуудын тунхаглаж баталсан Мянганы хөгжлийн¹ зорилтоос хүн төрөлхтөн асар ихийг хүлээж байна. Улс гүрнүүд амлалтаа өгч үүрэг хүлээсэн. Товлосон хугацаа хэдийнээ хаяанд ирсэн байна. Гэтэл Мянганы Хөгжлийн хэд хэдэн зорилт биелж амжихгүй болоод байна. Эмнести Интернэшнл засгийн газруудыг Мянганы Тунхаглалд амласан амлалтаа биелүүлэхийн тулд хүний эрхийн хэм хэмжээг хангах ажлыг нэн тэргүүнд хийх шаардлагатай гэж үзэж байна.

Мянганы Хөгжлийн Зорилтоор найман асуудлыг анхааралдаа авсныг дурдвал: 1. хэт ядуурал ба өлсгөлөнг устгах 2. бүх нийтэд анхан шатны боловсролыг хүртээмжтэй болгох, 3. жендэрийн тэгш байдлыг тогтооход дэмжлэг үзүүлж, эмэгтэйчүүдийг хүчирхэгжүүлэх, 4. хүүхдийн эндэгдлийг багасгах, 5. эхийн эрүүл мэндийг сайжруулах, 6. бэлгийн замын халдварт өвчин, хүний дархлал хомсдлын вирус /ХДХВ/, дархлалын олдмол хомсдол /ДОХ/, сүрьеэтэй тэмцэх, бусад өвчнийг бууруулах, 7. байгаль орчны тогтвортой байдлыг хангах, 8. дэлхийн хөгжлийн төлөө түншлэлийг эрчимжүүлэх² зэрэг болно. Эхний долоон асуудал нь глобал зорилттой уялдаж байгаа бөгөөд сүүлийн асуудал бол олон улсын байгууллагуудын хариуцсан ажил юм. Ихэнхи зорилтын товлот хугацааг 2015 он байна гэж тунхагласан.

Мянганы Хөгжлийн Зорилтууд олон улсын анхаарлыг хөгжлийн болон ядуурлыг бууруулах асуудалд хандуулах тал дээр чухал үүрэг гүйцэтгэсэн. Мөн иргэний нийгмийн байгууллагуудыг МХЗ-той үйл ажиллагаагаа уялдуулж ядуурал, гадуурхалтай тэмцэхэд нь үндэс суурь болж байгаа. Олон улсын төвшний хөгжлийн төлөөх байгууллагуудын олонхи нь Мянганы Хөгжлийн Зорилтыг дэмжихийн зэрэгцээ үйл ажиллагаандаа тэргүүлэх чиглэл болгосон. Зорилтондоо тохирсон арга зам боловсруулах үүднээс ахиц дэвшлийг үнэлэх шалгуур боловсруулсан.³

Гэхдээ асуудлыг авч үзэх цар хүрээ хийгээд, хийх ажил зарим талаар тодорхой бус үлдсэн. Гарсан ахиц дэвшил адилгүй байгааг НҮБ-аас анхааруулаад бодитой ажил хийхгүй бол 2015 он гэхэд дийлэнхи зорилт биелж амжихгүйг мэдэгдсэн.⁴

“Өнөөдөр Мянганы Хөгжлийн Зорилтыг биелүүлэхийн тулд хийх ажлаа тогтох шаардлагатай. Товлосон хугацаа хүртэл 5 жил үлдлээ. Амлалтаа биелүүлэхгүй байгаагаас болж тавьсан зорилтууд энэ хугацаанд амжиж биелэх боломжгүй болоод байна. Энэ бол ёс суртахууны үүднээс ч, амьдрал дээр ч зөвшөөрч боломгүй сүйрэл” юм.

Амлалтаа хэрэгжүүлэх нь: Мянганы Хөгжлийн Зорилт болон хийх ажлын төлөвлөгөө, НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын тайлан, 2010 оны 2-р сар

НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга цаг уурын өөрчлөлт, хүнсний болон санхүүгийн хямралаас үүдэлтэй шинэ асуудлууд тулгарч байгааг онцолсон.⁵ Мянганы Хөгжлийн Зорилтыг биелүүлэхээр ажиллахдаа иргэний, улс төрийн, эдийн засгийн, нийгэм, соёлын эрхийг хамгаалж, эдгээр эрхийг дэмжихэд үйл ажиллагаагаа чиглүүлэх амлалтаа хамтад нь хэрэгжүүлэх хэрэгтэй байна.⁶ Энэ нь Мянганы Хөгжлийн Зорилтын үр дүнг тогтвортой, ижил тэгш байлгахад амин чухал зүйл болно.

Мөн нэмж хэлэхэд улс орнуудын олон улсын хүний эрхийн хуулийн дагуу өгсөн амлалт Мянганы Хөгжлийн Зорилтод хангалттай тусгагдаж чадаагүй. Мянганы Хөгжлийн Зорилтод улс орнууд өөрсдийн бодлого, хөтөлбөрт тогтвортой хөгжлийн талаар тусгасан хэдий ч хүний эрхийн талаар тусгагдаагүй орхигдсон. ЭИ-ийн зүгээс дараах зүйлсийг Мянганы Хөгжлийн Зорилтыг хэрэгжүүлэхдээ тусгана гэдэгт найдаж байна:

- Улс орнууд хүний иргэний, улс төрийн, эдийн засгийн, нийгэм, соёлын эрхийг хүндэтгэн хамгаалах үүрэг амлалт өгсөн төдийгүй засгийн газрууд энэ амлалтаа үйл ажиллагаандаа хадгалан авч явах нь чухал байна. Мянганы Хөгжлийн Зорилтын хүрээнд үндэсний болон олон улсын төвшинд үр дүнтэй зөв механизм авч хэрэгжүүлэх нь хүмүүсийн өөрсдийн эрхийг хамгаалж, засгийн газруудыг амлалтаа биелүүлэхэд нь шахалт үзүүлэх
- Мянганы Хөгжлийн Зорилтын санаачилгууд нь хүний эрхийг хангах учиртай тул зайлшгүй шаардлагатай л биш бол хүмүүст амин чухал нийгмийн үйлчилгээ хүртэх боломжийг нь хязгаарлаж болзошгүй бодлогын өөрчлөлт хийх, хөрөнгө оруулалтаа хасаж, танахгүй байх нь чухал байна.⁷ Мөн улс орнууд Мянганы Хөгжлийн Зорилтын санаачилгууд нь хүний эрхийг зөрчихгүй байхыг хангах механизм бий болгох
- Ялгаварлан гадуурхаж, орхигдуулах нь ядуурлыг улам л гүнзгийрүүлнэ. Эдгээр нь хүмүүсийн нийгмийн үйлчилгээ авах боломжийг хязгаарлан ядуурлын эсрэг явуулж буй тэмцлийг үр дүнгүй болгодог. Ялгаварлахаас ангижрах асуудал бол олон улсын хүний эрхийн хуулиудын амин сүнс мөн.⁸ Эдгээр хууль, дүрэм

журмууд нь тэрхүү орхигдож гадуурхагдсан хүмүүст тэгш боломж олгох ёстой. Мөн Мянганы Хөгжлийн Зорилтын хүрээнд хийгдэж буй ажлууд нь эмэгтэйчүүдийн эрх, жендэрийн тэгш байдлыг хангаж байх ёстой.⁹ Мөн эмэгтэйчүүд охидод тулгарч буй хүндрэлийг анхааралдаа авч ажилдаа тусгах

- Улс орнууд хүний эрхийн хамгийн энгийн шаардлага болох орон байраар хангагдах, хүнс, ундны ус, эрүүл ахуй, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ авах болон нийгмийн үйлчилгээний эрхийг хангах асуудалд зайлшгүй анхаарлаа хандуулах.¹⁰ Мөн аливаа ажил явуулахдаа нийгмийн хамгийн эмзэг хэсгийнхний эрх ашгийг сайтар бодолцож анхаарал тавих.¹¹ Улс орнууд Мянганы Хөгжлийн Зорилтын хүрээнд хийгдэх ажлуудад эдгээр шаардлагуудыг тусган аливаа үйл ажиллагаандаа эрсдэлд буй хүмүүсийн эрх ашигт анхаарал тавьж ажиллах нь тэдний амьдралд сайн өөрчлөлт авчрахад зайлшгүй хэрэгтэй байна.
- Улс орнуудын гаргасан ололтыг үнэлэх хэмжүүр зайлшгүй шаардлагатай.¹² Зарим улсууд Мянганы Хөгжлийн Зорилтыг өөрсдийн нөхцөл байдал, боломж бололцоонд үндэслэн тогтоосон бол хэт доогуур зорилт тавьсан улс орнууд ч байна. Мөн тухайн улс орны тавьсан зорилтууд ил тод байхын зэрэгцээ улс орнууд үүрэг амлалтандаа хариуцлагатай хандаж, биелүүлж байх.
- Олон улсын хүний эрхийн баримт бичгүүдэд хүмүүсийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл олж авах, эвлэлдэж нэгдэх эрхийг тунхагласан.¹³ Иргэдийн оролцоог, хангаж тэдний бодол санааг тусгаж байж л Мянганы Хөгжлийн Зорилтууд биелэнэ гэдгийг бүх улс орнууд анхаарах ёстой.

Энэхүү тайланд жендэрийн тэгш байдал, эхийн эрүүл мэнд болон ядуус гэсэн гурван асуудлыг хөндөн тавьж байгаа юм. Энэ асуудлууд нь Мянганы Хөгжлийн Зорилт болон олон улсын хүний эрхийн хэм хэмжээ хоёрын холбоог харуулж чадах учраас сонгон авсан болно. Эндээс та бүхэн одоогийн Мянганы Хөгжлийн Зорилт болон олон улсын хүний эрхийн хэм хэмжээ хоёрын хооронд гарч буй ялгааг олж харна. Авсан жишээнүүд ч мөн бусад улсад түгээмэл байгаа. Харин төгсгөлд нь улс орнууд, олон улсын хөгжлийн болон санхүүгийн байгууллагад, НҮБ-ын харьяа байгууллагууд, хөтөлбөр, сан зэрэгт хүргүүлж буй бидний санал багтсан байгаа. Үүнд 2015 он хүртэлх хугацаанд хийх ажлуудыг хүний эрхийн хэм хэмжээнд нийцүүлэх асуудал тусгагдсан юм. Мөн 2015 оноос хойш ядуурлыг бууруулах ажилд тусгах шаардлагатай зарим зүйлсийг ч дурдсан болно.

10 жилийн өмнө хамгийн их орхигдож ядуурсан хүмүүсийн амьдралыг шинэ мянганд сайжруулахаар Мянганы Хөгжлийн Зорилтыг тунхагласан. Энэ хугацаанд зарим нааштай өөрчлөлт гарсан хэдий ч бодлого зорилтдоо өөрчлөлт хийхгүй бол 2015 гэхэд дийлэнхи зорилт биелэхгүй нь тодорхой байгаа юм. Харин өнөөгийн зорилт тодорхой байна. Ядуурлаас салж, эрхээ хангахаар тэмцэж буй хүмүүст зориулсан үр дүнтэй бодлого боловсруулах зайлшгүй шаардлагатай байна. Эмнести Интернэшнлийн зүгээс хүний эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хангаж өгөх нь ядуу хүмүүсийн амьдралыг сайжруулах нэгэн түлхүүр болно гэж найдаж байгаа юм.

БИДНИЙ САНАЛ

Эмнести Интернэшнл улс орнуудыг Мянганы Хөгжлийн Зорилтын үйл ажиллагааны төвдөө хүний эрхийн асуудлыг нэн тэргүүнд тавихыг уриалж байна.

Улс орнууд нь дараах зүйлсэд анхаарал тавих шаардлагатай байна. Үүнд:

1. Хариуцлагыг сайжруулах: Үндэсний болон олон улсын хариуцлагын механизмыг хэрэгжүүлэх шаардлагатай байна. Энэ нь улс орнууд Мянганы Хөгжлийн Зорилт болон хүний эрхийг хамгаалж, хангах тал дээр алдаа гаргасан үед алдаагаа засаж залруулах нэгэн нөхцөл болно. Мөн хүний эрхийн зөрчил гарсан үед алдааг засах үр дүнтэй механизм бий болгох.

2. Хүний эрхийн хэм хэмжээг хангаж буй эсэхийг хянах: Улс орнууд Мянганы Хөгжлийн Зорилттой холбоотой одоо мөрдөж буй хууль журам, бодлого хөтөлбөр хүний эрхийн хэм хэмжээг хангаж буй эсэхийг нягтлах хэрэгтэй байна. Энэхүү хяналт, үнэлгээний үр дүнг ажил хэрэг болгох тал дээр анхаарал тавих.

3. Орхигдсоныг залруулах: Улс орнууд Мянганы Хөгжлийн Зорилтын үйл ажиллагаанууд шаардлагатай бүхий л нийгмийн бүлгийг хамруулж ажиллахдаа жендэрийн тэгш байдлыг хангаж, нийгмийн эмзэг хэсгийн эрх ашгийг нэн тэргүүнд тавьж ажиллах.

4. Үндэсний түвшний зорилт тавьж ажиллах: Улс орнууд хүний нийгэм, эдийн засаг, соёлын эрхийг ханган, хамгийн богино хугацаанд биелэх үндэсний түвшний зорилт тавьж ажиллах хэрэгтэй. Мөн өнгөрсөн хугацаанд гарсан ахиц дэвшил хийгээд дотоодын нөөц бололцоогоо (мөн олон улсын дэмжлэг) бодитоор тооцсон, тодорхой хугацаатай, үр дүнг нь үнэлж болохуйц зорилт дэвшүүлэн ажиллах.

5. Оролцоог хангах: Улс орнууд ядуу нөхцөлд амьдарч буй хүмүүсийг Мянганы Хөгжлийн Зорилт болон түүний төлөвлөлт, хэрэгжүүлэлт, хяналт үнэлгээнд бодитоор оролцох боломжийг хангаж өгөх хэрэгтэй. Мөн эмэгтэйчүүдийн эрх тэгш оролцох боломжийг бүрдүүлэн, хүний эрхийн төлөө тэмцэгчдийн ажиллах боломжийг бий болгохын зэрэгцээ хүмүүсийн мэдээллийн эрх, үзэл бодлоо илэрхийлж, эвлэлдэн нэгдэх эрхийг баталгаажуулах.

6. МХЗ-ын хүрээнд хэрэгжиж буй олон улсын дэмжлэг, хамтарсан үйл ажиллагаа нь хүний эрхийн хэм хэмжээг хангаж буй тал дээр анхаарал тавих.

2 ДУГААР БҮЛЭГ: ХҮНИЙ ЭРХ БА МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ

“Мянганы Тунхаглал болон олон улсын хүний эрхийн баримт бичгүүдээр тогтоосон хэм хэмжээ нь хүний эрхийн үндсэн зарчим болох ялгаварлан гадуурхахгүй байх хийгээд бодитой оролцоог хангах, хариуцлагыг хэрэгжүүлэх үндэс суурь болох ёстой.”

Амлалтаа хэрэгжүүлэх нь: Мянганы Хөгжлийн Зорилт, үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, НҮБ-ын ЕНБД-ын тайлан, 2010 оны 2-р сар

Мянганы Хөгжлийн Зорилтуудад хүний эрхийн асуудлыг онцгойлон авч үзээгүй төдийгүй зарим зорилт нь улс орнуудын зүгээс олон улсын хүний эрхийн гэрээгээр хүлээсэн үүргээс нь доогуур түвшинд тусгагдсан, зарим зорилтуудад ядуурлыг ихэсгэж буй хүний эрхийн зөрчлийн асуудлыг огт тусгаагүй байна. Мянганы Хөгжлийн Зорилтуудад олон улсын хүний эрхийн хэм хэмжээг тусгаж өгөх нь ирэх жилүүдэд ахиц дэвшил гаргах үндэс болж өгнө. Иймд засгийн газрууд өөрийн орны Мянганы Хөгжлийн Зорилт хүний эрхийн хэм хэмжээг хангаж буй эсэхийг нягтлан, эмэгтэйчүүд болон нийгмийн эмзэг бүлэгт тулгарч буй ялгаварлан гадуурхалтад анхаарлаа хандуулахын зэрэгцээ өөрийн орондоо тохирсон үндэсний зорилт тавьж ажиллах хэрэгтэй. Үүний зэрэгцээ хүмүүсийн оролцооны эрхийг хангаж, хариуцлагын механизмыг сайжруулах нь чухал.

БҮГДИЙГ ХАМРУУЛАХ

Олон улсын хүний эрхийн хуулийн дагуу бүх улс орон иргэдийнхээ эрх тэгш байдлыг хангах ёстой. Харин Мянганы Хөгжлийн Зорилтуудад ялгаварлан гадуурхалыг устгах асуудлыг тусгаагүй юм.¹⁴

Мянганы тунхаглалд олонтаа дурдсан эмэгтэйчүүдийн эсрэг бүхий л хэлбэрийн хүчирхийлэлтэй тэмцэж, устгах зорилт Мянганы Хөгжлийн Зорилтуудад тун хангалтгүй тусгагджээ. Мянганы Хөгжлийн 3 дугаар зорилтод жендэрийн тэгш байдлыг ханган эмэгтэйчүүдэд эрх мэдэл олгох асуудал ганцхан боловсролын салбар дахь хүйсийн асуудлаар хязгаарлагдсан байна. Мөн цалинтай ажил эрхэлж буй эмэгтэйчүүдийн тоо, парламент дахь эмэгтэйчүүдийн суудал гэсэн хоёрхон үзүүлэлт л багтаж орсон байна. Энэ нь Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах конвенцийн дагуу улс орнуудын өгсөн амлалтаас хол зөрж буй хэрэг болно. Энэхүү конвенцийн дагуу улс орнууд эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхаж буй байдлыг устган эрх тэгш байдлыг бүхий л төвшинд хангаж өгөхөөр тогтсон билээ.¹⁵

Олон улсын хүний эрхийн хууль журамд арьсны өнгө, нийгмийн давхарга, яс үндэс, хөгжлийн бэрхшээлтэй байдлаар нь болон уугуул иргэний эрх зүйн байдлаар нь ялгаварлан гадуурхахыг хориглосон. Ялгаварлан гадуурхах асуудал ядууралтай нягт холбоотой атал Мянганы Хөгжлийн Зорилт энэ тал дээр асар их дутагдал байна.

НҮБ-ын уугуул иргэдийн асуудал эрхэлсэн байнгын хороо ядуу болон нэн ядуу иргэдийн дунд уугуул иргэд олон байгаа бөгөөд тэдэнд үзүүлж байгаа нийгмийн, эрүүл мэндийн, боловсролын үйлчилгээ дунджаас доогуур түвшинд байгааг онцлон тэмдэглэсэн. Мөн хүрээлэн буй орчны өөрчлөлтөд уугуул иргэд хамгийн ихээр нэрвэгдэж байна гэж мэдэгдсэн. Үүний зэрэгцээ бусад иргэдийг бодоход уугуул иргэд хөгжлийн үр дүнг хүртэх тал дээр дутагдалтай байгаа бөгөөд ялангуяа эмэгтэйчүүд хүйсээр ялгаварлан гадуурхаж буй асуудалд хамгийн өртөмтгий байгааг онцолсон юм.

ЯКИ АКСА БОЛОН САХОЯМАСА

“Зам дагуу амьдарч буй уугуул иргэдийн дутагдаж гачигдсан амьдрал асар эмгэнэлтэй байна”. Америк тивийн хүний эрхийн шүүх, 2005 оны 6 дугаар сарын 17.

Прагвайн Яки Акса болон Сахоямасагийн иргэдийн амьдралаас та бүхэн уугуул иргэдийн эрхийг хамгаалах асуудал хурцаар тавигдаж байгааг харж болно. Уугуул иргэдийн эрхийг хамгаалахгүй байгаагаас үүдэн ядууралд нэрвэгдэх, хоол хүнс, ундны цэвэр ус, эрүүл мэндийн үйлчилгээ авах зэрэг болон бусад эрх нь зөрчигдсөөр байна.

Яки Акса болон Сахоямасагийн уугуул иргэд ундны ус, хоол хүнс, эрүүл мэндийн үйлчилгээ хомс нөхцөлд хурдны замын дагуу амьдарч байгаа юм. Үе дамжин амьдарч байсан газар нь бусдын мэдэлд орсон бөгөөд 2005, 2006 онд Америк тивийн хүний эрхийн шүүх уугуул иргэдэд үе залгамжилсан нутгийг нь буцаан өгөх нь уугуул иргэдийн эрхийг хангахад чухал нөлөө үзүүлнэ гэж тогтсон байна. Шүүхийн шийдвэр гарснаас хойш Яки Акса болон Сахоямасагийн 27 уугуул иргэн нас барсан байна.

Уугуул иргэдийн нутгийг буцаан өгөх Хүний эрхийн шүүхийн шийдвэрийг биелүүлэх хугацаа хэдийнэ өнгөрсөн. Шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх ажил үр дүнд хүрэхгүй байсаар 2009 онд Прагвайн сенат уугуул иргэдэд газрыг буцаан өгөлгүйгээр өөр газар олгох шийдвэр гаргажээ. Газраа буцаан авч чадаагүй уугуул иргэдийн хүнд амьдрал үргэлжилсээр байна.

Уугуул иргэдийн байнгын хорооноос Мянганы Хөгжлийн Зорилтын үйл ажиллагаа болон тайлангуудад уугуул иргэдийн асуудал тусгагдахгүй байгааг анхааруулсаар байна. Мөн уугуул иргэдийн асуудлыг онцгойлон авч үзэхгүй бол “Мянганы Хөгжлийн зарим Зорилт уугуул иргэдийг газар нутгаа алдах, өөр газруудад суурьшихад хүргэж байгаа бөгөөд үүнээс шалтгаалан тус иргэдийн соёл, ёс заншил алдагдахад хүргэж байна” гэж мэдэгдсэн юм.¹⁹

Үйл ажиллагааны үр дүнг хэмжих хувь тэнцүүлсэн аргачлал хэрэглэж байгаагаас шалтгаалан зарим улс туйлын хүнд нөхцөлд амьдарч байгаа иргэдийн асуудлыг орхигдуулсан хэр нь ахиц гарч буй мэтээр мэдээлсээр байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн төлөө тэмцэгчдийн мэдэгдсэнээр “нэн ядуу нөхцөлд амьдарч буй хүмүүсийн 20 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудал Мянганы Хөгжлийн Зорилтын 8 зорилт, 18 зорилго, 48 шалгуур үзүүлэлтийн аль алинд багтаагүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудал олон улсын ядуурлыг бууруулах стратеги төлөвлөгөөнд тусгагдаагүй байна.”²⁰

Хөгжиж буй орнуудын ядуурлын асуудалд хэт анхаарлаа хандуулаад хөгжингүй орнуудын ядуурлын асуудлыг анхаарахгүй орхих нь ялгаварлан гадуурхах, орхигдуулах аюулыг авчраад байна. Жишээлэхэд Европт цыган иргэд бусад иргэдээс онцгой ялгаатай нөхцөлд амьдарч байна. Олонхи цыган иргэд орон сууцны хүндрэлтэй нөхцөлд ундны ус, эрүүл ахуй, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээнээс ангид нөхцөлд амьдарч байна.²¹

Ялгаварлан гадуурхахыг устгах асуудал зөвхөн Мянганы Хөгжлийн Зорилтууд төдийгүй төлөвлөлт, хяналт үнэлгээний асуудалд хөндөгдөлгүй үлдсэн юм.

ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭ ХИЙХ, ТАЙЛАГНАХАД ТУЛГАРЧ БУЙ АСУУДЛУУД

50 улсын Мянганы Хөгжлийн Зорилтын тайланг судлан үзсэн НҮБ-ын цөөнхийн асуудал эрхэлсэн бие даасан шинжээчид угсаатан болон хэлний цөөнхийн талаар ердөө 19 улс тайландаа тусгасан байгааг мэдэгдсэн юм. Мөн тайланд дурдсан хэдий ч цөөнхөд тулгарч буй асуудлыг шинжилсэн, тулгарч буй асуудлыг тодорхой авч үзсэн удаа байхгүй байгааг онцолсон юм.²²

Улс орнуудаас боломжтой бол тайлан ирүүлэхдээ хүйс, хот, хөдөө амьдрагчид тус бүрд нь мэдээллээ ялган ирүүлж байх хүсэлт тавьсан.²³ Гэсэн хэдий ч ялгаварлан гадуурхалт, орхигдуулах асуудлуудаар уугуул болон цөөнхи иргэдийн мэдээллийг хэрхэн бэлтгэх тал дээр тодорхой заасан зүйл байхгүй юм. НҮБ-ын уугуул иргэдийн асуудал эрхэлсэн байнгын хорооноос тун цөөхөн улс орон л мэдээллээ тус тусад нь бэлтгэн ирүүлсэн болохыг мэдэгдсэн.²⁴

Зарим улс орнууд гадуурхагдсан хүмүүсийн асуудлыг онцгойлон авч үзэж, хяналтын бүтцийг бий болгосон. Хүний эрхийн дээд комиссарын ажлын албаны мэдэгдсэнээс үзэхэд Тайланд улс үндэсний төвшинд цөөнхийн асуудлаар явуулж буй үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийг тусад нь боловсруулсан байна. Мөн Эквадор улс эмэгтэйчүүд, уугуул иргэд болон африк үндэстнүүдийн асуудлыг илүү тодорхой харуулах үүднээс нэмэлт шалгуур үзүүлэлтүүд бэлдсэн байна.²⁵ Гэсэн хэдий ч бүх улс орон Мянганы Хөгжлийн Зорилтоо төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавихдаа ялгаварлан гадуурхалыг халах, хүнд нөхцөлд амьдардаг хүмүүсийн нийгмийн үйлчилгээ авах боломжийг хязгаарлаж буй саад тотгорыг устгах асуудлыг онцгойлон авч үзэх тал дээр идэвхитэй ажиллах шаардлагатай байна.

ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ СОЁЛЫН ЭРХИЙН ТАЛААР УЛС ОРНУУДЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ ²⁶

Олон улсын хууль журмын дагуу улс орнууд үе шаттайгаар хүмүүсийн нийгэм, эдийн засаг, соёлын эрхийг хангах үүрэгтэй билээ.²⁷ Улс орнууд сайтар бодож боловсруулсан, тодорхой бодлого төлөвлөн хэрэгжүүлэх хэрэгтэй байна.²⁸ Өөрийн улсын нөөц бололцоо болон олон улсын байгууллагуудын дэмжлэгийг дээд зэргээр ашиглан хариуцлагатайгаар ажиллах шаардлагатай. Бусдад туслах боломжтой улс орнууд ч хүний үндсэн эрхийг хангах тал дээр туслалцаа үзүүлэх шаардлага гарсаар байна. Мөн улс орнууд хэрхэн тавьсан зорилтоо биелүүлэх, мөн үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт боловсруулах тал дээр анхаарлаа хандуулж үндэсний стратеги, төлөвлөгөөгөө өөрчлөн засаж залруулах хэрэгтэй байна.²⁹

Үүний зэрэгцээ улс орнууд хүний нийгэм, эдийн засаг, соёлын эрхийг бодитой бий болгон, хүний эрхийг дээдлэх тал дээр нэн даруй үйл ажиллагаагаа чиглүүлэх шаардлагатай байна.³⁰ Мөн хүний эрхэд шууд болон шууд бусаар халдахыг хориглож, гуравдагч этгээд хүний эрхэд халдахаас сэргийлэх, хүний эрх зөрчигдвөл шалгаж, хариуцлага хүлээлгэх замаар хүний эрхийг баталгаажуулах шаардлагатай. Мөн хүний эрхийг хууль зүйн, захиргааны, шүүхийн, төсөв санхүүжилтийн болон бусад шаардлагатай арга замаар хангаж өгөх хэрэгтэй байна. Энэ бүгдийг ажил хэрэг болгож байж л хүний эрх баталгаажих болно.

Мянганы Хөгжлийн Зорилтуудад энэ бүхэн тусгагдаагүй байж болох ч эдгээр зүйлс бол амин чухал, зайлшгүй хийх ажил мөн.

ОЛОЛТ АМЖИЛТЫГ БОДИТООР ҮНЭЛЭХ МЕХАНИЗМ БИЙ БОЛГОХ НЬ

МХЗ-ын хүрээнд дэлхийн хэмжээний зорилтыг тунхагласан. Ингэхдээ 2 чухал зүйлийг орхигдуулсан. Нэгд, Мянганы Хөгжлийн Зорилт нь улс орнуудын гаргаж буй ахиц дэвшил хийгээд санхүүгийн боломж (үүнд мөн олон улсын тусламж дэмжлэг ч багтана) зэрэг хүчин зүйлсийг бодитоор тооцож чадаагүй. Мөн хүний нийгэм, эдийн засаг, соёлын эрхийг хангахын ач холбогдлыг орхигдуулсан.

Хоёрт, Зорилтын хэрэгжилтийг үнэлэх шалгуурыг нь маш доогуур тогтоосон нь (шалгуур үзүүлэлтийг сайн дураараа өөрсдийн нөхцөлд тохируулан өндөрсгөсөн улс орнууд ч бий) олон улсын хүний эрхийн хэм хэмжээтэй зөрчилдөж байна.

ДЭЛХИЙН ТҮВШНИЙ ЗОРИЛТЫН ЭРГЭН ТОЙРОНД

Олон улсад тогтсон стандартыг хэрэглэн улс орнуудын гаргаж буй ахиц дэвшлийг гүйцэтгэлийн түвшингээр нь харьцуулах боломжтой юм. Ингэж харьцуулалт хийснээр зарим улс орны гүйцэтгэлийн шалгуурыг өндөрсгөх боломж гарч ирж байна. Гэхдээ Мянганы Хөгжлийн Зорилтын зарим зорилт нь улс орнуудын дотоод нөөц бололцоонд (олон улсын тусламж дэмжлэг ч үүнд орно) бодитоор тулгуурлаж чадаагүйг хэлэх хэрэгтэй. Үр дүнд бодит бус зорилт ч тавигдах болсныг олонтаа харж болохоор байна. Үүний нэг жишээ бол 7 дугаар зорилтын 11 дүгээр зорилго болох 100 сая ядуусын хорооллын суугчдын амьдралыг сайжруулах зорилго мөн. Энэ зорилтыг “Ядуусгүй хотууд – Ажлын төлөвлөгөө”-нд гаргаж ирсэн бөгөөд хандивлагчид болоод олон улсын байгууллагуудын хүч бололцоонд тулгуурласан юм.³¹ Харин улс орнуудыг нөөц бололцоогоо энэ чиглэлд хандуулан, үйл ажиллагаагаа зориулах, улс орнууд өөрсдийн иргэдийг хүчээр нүүлгэн шилжүүлэхгүй байх, элдэв дайралтаас хамгаалах үүрэг амлалтыг чиглүүлэх тал дээр хангалттай тусгаж өгөөгүй байна. Үүнээс үүдэн ядуусын хороололд амьдарч буй нэг тэрбум хүний амьдралыг сайжруулах боломжийг алдсан.

Мянганы Хөгжлийн Зорилтын хүрээнд 1990-2015 оны хооронд хоногт 1 америк доллараас бага мөнгөөр амь зууж буй хүмүүсийн тоог нэг дахин багасгах зорилт орсон.³² Энэ зорилтыг урьд өмнөх тооцоон дээр тулгуурлан³³ боловсруулснаас болж маш их боломжийг алдсан. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн олон улсын гэрээний дагуу улс орнуудын нөөц боломжийг бүрэн дүүрэн ашигласан бол илүү их амжилт олох байсан. Улс орнуудын олон улсын хуулийн дагуу өгсөн үүрэг амлалтыг уг зорилтонд нийцүүлэн ажиллаагүйгээс болж орлогын ядуурлыг бууруулах зорилт хангалтгүй байна. Энэтхэг болон Хятад улс Мянганы Хөгжлийн Зорилтоос ч өмнө гаргаж тавьсан зорилтоо биелүүлэхэд л энэ зорилт биелэсэн харагдахаар тооцоо гарсан байна.³⁴

8 дугаар зорилтод өндөр хөгжилтэй орнууд бусад 7 зорилтонд хүрэхийн тулд хөгжиж буй орнуудад туслалцаа үзүүлэх амлалт тусгагдсан хэдий ч тодорхой хугацаа заасан зүйлгүй байгаа нь хөгжилтэй орнуудын амлалтыг нэхэх, хариуцлагатай байдлыг шаардахад хүндрэлтэй болгож байна.

ҮНДЭСНИЙ ЗОРИЛТУУД

Зарим улс орон өөрсдийн зорилтыг Мянганы Хөгжлийн Зорилтоос илүү түвшинд хүргэх зорилт тавин ажиллаж байна. Жишээлбэл, Латин Америкийн зарим орнууд Мянганы Хөгжлийн Зорилтын амлалтаа ахиулан дунд шатны боловсролын асуудлыг багтаахаар шийдвэрлэсэн байна.³⁵ Кени, Өмнөд Африк, Шри Ланк улсууд ундны болон эрүүл ахуйн асуудлаар Мянганы Хөгжлийн Зорилтын цар хүрээнээс илүү гарсан зорилт тавин өөрсдийн бодлогыг цэвэр усны хангалтыг сайжруулах, эрүүл ахуйг сайжруулахад чиглүүлэн ажиллаж байна.³⁶ Гэсэн хэдий ч дийлэнхи улсууд глобал зорилтуудыг шууд авч хэрэглэж байгаа бөгөөд энэ нь тэдний явуулах үйл ажиллагаа нь олон улсын хүний эрхийн хуулинд зааснаас доогуур түвшинд байна гэсэн үг юм. Мянганы Хөгжлийн Зорилтын үнэлгээний дүнд улс орнуудаа эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хангахад нааштай ахиц гаргахын тулд үндэсний зорилтуудаа олон улсын хүний эрхийн хуулийн дагуу өгсөн амлалтандаа тохируулан хэрэгжүүлэх олон талын санал гарч ирж байгаа юм. Үндэсний зорилтууд болон яаралтай хийх шаардлагатай ажлуудаа сайтар тогтоох нь ажлын үр дүнг сайжруулж,

үүрэг хариуцлага хийгээд хяналтыг сайжруулахад тустай. 2015 хүртэл Мянганы Хөгжлийн Зорилтуудад өөрчлөлт оруулах нь боломжгүй байж болох хэдий ч улс орнууд хурдан үр дүнд хүрэхийн тулд өөрсдийн үндэсний зорилтыг сайжруулан өөрчлөх боломж байсаар байна. Хэрэв үүнийг ажил болгож чадвал бүх улс орон Мянганы Хөгжлийн Зорилтын үйл ажиллагаандаа амжилт олох боломжтой.

Мянганы Хөгжлийн Зорилтыг өөрийн орны нөхцөлд тохируулалгүйгээр, шууд үйл ажиллагаандаа авч хэрэглэж байгаа нь шаардлагатай олон ажлыг орхигдуулах нэг шалтгаан болж байна. Жишээлбэл Мянганы Хөгжлийн Зорилтод мэдээлэл хомс байгаагаас шалтгаалж нийгмийн үйлчилгээний хүрэлцээ, чанарын асуудал тусгагдаагүй байна. Мянганы Тунхаглалд ундны цэвэр усны хомсдолд буй хүмүүсийн тоог нэг дахин бууруулна хэмээн тунхагласан.³⁷ Гэтэл дэлхийн улс орнуудын усны хэрэглээний мэдээлэл дутмагаас болоод Мянганы Хөгжлийн Зорилтод цэвэр усны асуудал тун хангалтгүй тусгагдсан байна. Усны хоолой болон хамгаалалттай худгаас авч буй усны³⁸ (эдгээрээс бохирдсон ус ч гарах нь бий) мэдээлэл дээр үндэслэн усны хэрэглээний тооцоо хийх нь учир дутагдалтай.

Хүний эрхийн хэд хэдэн амин чухал асуудал Мянганы Хөгжлийн Зорилтод тусгагдаагүйг дурдвал нийгмийн хамгааллын эрх, эрүүл мэндийн эрх (үүнд олон сая хүнийг хамарсан халдварт өвчнүүд орно) зэрэг болно. ДЭМБ-ын мэдээлснээс үзэхэд халдварт өвчин буурай хөгжилтэй орнуудын хөдөө нутгийн хүмүүсийг ихэвчлэн хамарч байна.³⁹ Ийм улс орнууд олон сая хүний амьдралд бодитой ахиц дэвшил гаргахын тулд Мянганы Хөгжлийн Зорилтуудад тусгагдаагүй эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн олон асуудал дээр үндэсний шалгуур боловсруулах хэрэгтэй байна.

ШИЙДВЭР ГАРГАХАД ОРОЛЦОХ

Олон улсын Иргэний болон Улс төрийн эрхийн протоколд иргэн бүр олон нийтийн үйл ажиллагаанд оролцох эрхтэй гэж тунхагласан.⁴⁰ Мөн НҮБ-ын Эдийн засаг нийгэм соёлын эрхийн хороо засгийн газрын бодлого, шийдвэр иргэдийн оролцооны эрхийг хангаж байх ёстойг онцлон сануулсан.⁴¹ Эрүүл мэндийн үйлчилгээний асуудлаас ч мөн иргэдийн оролцооны ач холбогдлыг олж харж болно.⁴² Иргэдийн оролцоог бодитой болгохын тулд засгийн газрууд иргэдийн үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хангахын зэрэгцээ хүний эрхийн төлөө тэмцэгчдэд үйл ажиллагаагаа явуулах боломж олгох шаардлагатай байна.

Мянганы Хөгжлийн Зорилтод иргэдийн оролцооны эрхийн асуудлыг хангалттай тусган өгч чадаагүй. Үүнээс болж ядуу нөхцөлд амьдарч буй хүмүүс Мянганы Хөгжлийн Зорилтын хүрээнд явуулж буй үйл ажиллагаануудыг төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах үйл ажиллагаанд оролцож чадахгүй байна. Иргэдийн нийгмийн асуудалд чиглэсэн үйл ажиллагаанд иргэний байгууллагууд, нийгмийн хөдөлгөөнүүдийн болон иргэдийн оролцоо тун хангалтгүй байна.⁴³ Ихэнхидээ оролцооны асуудал ор тас орхигдсоор байна.⁴⁴

НҮБ-ын Уугуул иргэдийн байнгын хороо Африк, Латин Америк, Ази Номхон далайн бүсийн 25 улсын⁴⁵ Мянганы Хөгжлийн Зорилтын үндэсний тайланг судалж үзээд Мянганы Хөгжлийн Зорилтын дагуу явуулж буй үйл ажиллагааны болон хяналт тавих бодлогод уугуул иргэдийн оролцоо тун хангалтгүй төдийгүй уугуул иргэдийн оролцоог бүрдүүлэх механизм байхгүй байгааг тогтоосон байна. Эцэст нь тус хороо дүгнэхдээ, "Цаашид засгийн газрууд уугуул иргэдийн бодитой оролцоог бий болгож, тэднийг үйл ажиллагаа төлөвлөх, бэлтгэхэд анхнаас нь оролцуулах нөхцлийг бүрдүүлэх шаардлагатай байна."⁴⁶ Мөн "Уугуул иргэдийг

тэдний амьдрал ахуйтай холбоотой аливаа санаачлага, үйл ажиллагаанд чөлөөтэй, давуу эрхтэйгээр, бүрэн мэдээлэлтэйгээр оролцох нөхцлийг бүрдүүлэх шаардлагатай. Өмнө нь сайтар судлаж бэлтгэсэн гэх шалтгаанаар уугуул иргэдийн оролцоог үгүйсгэж байгааг халж, тэднийг бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, дүгнэх үйл ажиллагаанд идэвхитэй оролцуулж байх шаардлагатай.”⁴⁷

Үр дүнтэй үйл ажиллагаа явуулахын тулд иргэдийн оролцоог хангаж, иргэдтэй урьдчилан зөвлөлдөж байж хэрэгжүүлэх нь амин чухал. Үүнийг үндэсний болон олон улсын түвшинд явуулж буй бүх ажилд хэрэгжүүлэх нь чухал байна.

ЭНЭТХЭГ УЛСЫН МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ

Маздур Кисаан Шахти Сангатаны удирдсан олон нийтийг хамарсан кампанит ажлын дараа Энэтхэг улс 2005 онд Мэдээллийн эрх чөлөөний хууль гаргасан байна. Уг кампанит ажил нь ядуу хүмүүст мэдээлэл олж авах боломж байхгүй байгаа, энэ нь эргээд хүнсний тусламжийн тогтолцоо авилгад идэгдэх нөхцөл болж байгааг эсэргүүцсэн тэмцэл байсан юм.⁴⁸ Мэдээллийн эрх чөлөөний хууль төв засгийн газар болон муж улсууд, нутгийн захиргааны байгууллагууд, засгийн газраас тусламж авагчдыг хамардаг. Уг актаар нутгийн захиргааны албан тушаалтнууд иргэдийг хүссэн үед нь мэдээллээр хангах үүрэгтэйг заасан байна. Мөн иргэдийг тогтсон хугацаанд мэдээллээр хангаагүй, мэдээлэл өгөхөөс татгалзсан түшмэдэд хүлээлгэх хариуцлагыг ч тусгасан байна.

Уг хуулинд зарим нэг дутагдалтай, хязгаарлагдсан зүйлс байгаа хэдий ч бүхэлдээ Энэтхэг улсад ил тод, хариуцлагатай байдал бий болоход чухал дэвшил боллоо гэж үзэж болно. Хууль хэрэгжиж эхэлснээс хойш олон нийтийн үйлчилгээнд байгаа авилгалтай тэмцэл хийсэн хэд хэдэн тохиолдол гарсан байна.⁴⁹ Хамгийн чухал нь иргэд хүнсний карт, үнэмлэх, татвар авах зэрэг тэдний амьдралд чухал нөлөөтэй асуудлаар мэдээлэл олж авах боломжтой болж байна. Мөн Дели хотын усны шинэчлэл зэрэг томоохон асуудал дээр өөрсдийн эрх ашгийг хамгаалах, шаардах эрхтэй болсон юм.

ХАРИУЦЛАГА, АЛДААГ ЗАЛРУУЛАХ АСУУДАЛ

Улс орнуудын Мянганы Хөгжлийн Зорилтын хүрээнд хийж буй үйл ажиллагаанд олон улсын хяналт тун хязгаарлагдмал байна.⁵⁰ Зөвхөн өөрсдийн илгээсэн тайлангийн хүрээнд сайн дураар тайлагнах төдийгөөр хяналтын асуудал хязгаарлагдаж байна. Мөн тайландаа нарийвчилсан мэдээлэл оруулалгүйгээр бүрхэгдүүлэх, тайлангаа тогтмол шинэчлэхгүй байх нь элбэг байна. НҮБ-ын эдийн засаг, нийгмийн зөвлөлд (жил тутам сайд нарын түвшинд болдог хэлэлцүүлэг) сайн дураар танилцуулга хийж тайлагнасан 8 улс л байна.

Мянганы Хөгжлийн Зорилтын үйл ажиллагаанд хүний эрхийн хэм хэмжээг мөрдөж, үндэсний болон олон улсын хариуцлагын механизмыг бий болгох нь ядуу хүмүүс, иргэний нийгмийн байгууллагуудын өмнө засгийн газруудыг үүрэг амлалтаа сахиж хариуцлагатай ажиллах нэгэн нөхцөл болж өгнө.

Эмнести Интернэшнлийн Буркина Фасод хийсэн нэгэн судалгаа хариуцлагын асуудлын чухлыг харуулна. Засгийн газрын гаргасан жирэмсэн эхчүүдэд үзүүлэх эмнэлгийн тусламжийн бодлогыг хууль бус төлбөр нэхсэн эмнэлгүүд хэрэгжүүлдэггүй ажээ. Гомдолтой эхчүүд хаана хандахаа мэддэггүй байна. Хууль бус явдалд хариуцлага хүлээлгэх механизм эмнэлгийн байгууллагад өөрт нь ч, хуулийн байгууллага, шүүхэд ч байдаггүй байна.⁵¹ Хэрэв хариуцлагын механизм бүрдүүлвэл тус улсын засгийн газрын бодлого төдийгүй төрөх эхчүүд, тэдний гэр бүлийнхэнд өөрсдийн эрхийг эдлэхэд нь сайнаар нөлөөлөх нь ойлгомжтой юм. Хариуцлагыг сайжруулах, алдаа дутагдлыг арилгаж, залруулах нь бодлого гаргахад орхигдсон хүмүүстэй цаашид хамтран ажиллахад ач холбогдолтой.

ҮНДЭСНИЙ ХАРИУЦЛАГЫН МЕХАНИЗМ

Ядуу нөхцөлд амьдарч буй олон хүнд шүүх, хуулийн байгууллагад хандахад олон бэрхшээл тулгардаг байна. Энэ бэрхшээлүүдийг арилгаж шүүх байгууллагуудад иргэдийн эрхийг хамгаалах бололцоог бүрдүүлэх шаардлагатай. Хуулийг ч гэсэн иргэдийн бүхий л эрхийг хамгаалах чиглэлд өөрчлөх хэрэгтэй. Иргэний нийгмийн байгууллагуудыг шүүхэд иргэдийг төлөөлөн оролцох боломжийг хангаж, шүүхийн хараат бус байдал, шүүхийн шийдвэрийг хэрэгжилтийг сайжруулах хийгээд бага орлоготой иргэдийг шүүхийн төлбөр хураамжаас чөлөөлөх нь иргэдийн шүүхэд хандаж, гомдолоо гаргах үйл явцыг хялбар болгоно.

Үндэсний түвшинд хуулийн байгууллагуудыг багтаасан хянах чиг үүрэгтэй тогтолцоог (үндэсний комисс, парламентийн бүтцийн болон зохицуулах албад зэрэг) бий болгон хариуцлагын механизмыг бүрдүүлэх хэрэгтэй. Мөн засгийн газрыг үүрэг хариуцлагатай ажиллахад нь нөлөөлөхийн зэрэгцээ явуулж буй бодлого нь дотоодын болон олон улсын хуулийг даган мөрдөж буй эсэхийг хянах, засгийн газрын бүтцийн байгууллагуудыг бодлогын түвшний өөрчлөлтийг хийж буй эсэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэх хэрэгтэй байна. Өмнөд Африкийн Үндсэн хуулийн шүүх хууль зүйн тогтолцоонд засгийн газар иргэдтэй ижил статустай байх нь оролцооны ардчиллыг хөхиүлэн дэмжиж, засгийн газрыг сонгуульт хугацаандаа иргэдийнхээ өмнө хариуцлагатай байлгах тун чухал үүрэг нөлөөтэй. Энэ хүрээнд засгийн газрууд бодлогоо чухам ямар үндэс шалтгааныг харгалзан үзэж тодорхойлсон болохоо ил болгох шаардлагатай⁵² гэж үзсэн байна.

Хүний эрхийн Үндэсний комисс, тухайлан гомдол хариуцсан албан хаагч болон олон нийтийн байгууллагууд шүүхэд хандах иргэний боломжийг хангахад чухал үүрэг гүйцэтгэх талтай. Ийм байгууллагууд нь хохирогчийн өмнөөс мөрдөлт хийх, хуулийн хийгээд бодлогын шаардлагатай засвар өөрчлөлтийг шаардах, шүүхийн өмнө хохирогчийг төлөөлөх зэрэг үйл ажиллагааг явуулж болох юм. Харин засгийн газрууд эдгээр байгууллагын ажиллах боломжийг ханган өгч Мянганы Хөгжлийн үндэсний зорилтын хүрээнд явуулж буй үйл ажиллагаанд үр дүнтэй хяналт тавих нөхцлийг бүрдүүлэн өгөх шаардлагатай байна. Мөн эдгээр байгууллагад хүний бүхий л эрхийн (эдийн засаг, нийгэм, соёлын) асуудлаар ажиллах боломжийг хангаж өгөх шаардлагатай байна. Цэвэр ус, эрүүл ахуй, эрүүл мэнд боловсролын үйлчилгээнд хяналт тавьж зохицуулах үүрэгтэй байгууллагууд хэдий нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмж дээр анхаарлаа хандуулж буй ч хүний эрхийн хэм хэмжээ, үүнээс үүдэлтэй гомдлын асуудлуудад анхаарал тавих талаар туйлын хангалтгүй байна. Иймд засгийн газрууд эдгээр байгууллагын үйл ажиллагаанд хүний эрхийн хэм хэмжээг мөрдүүлж, иргэний гомдлыг авч үзэх тал дээр шаардлага тавих хэрэгтэй байна. Мөн иргэдэд гомдол гаргах талаар мэдээлэл хүргэх шаардлагатай байгаа юм.

Парламентийн бүтцийн байгууллагууд Мянганы Хөгжлийн Зорилт, түүнтэй холбоотой үйл ажиллагаанд хүний эрхийн үүднээс хяналт тавьж хүний эрхийн зөрчлөөс сэргийлэхэд маш чухал үүрэг гүйцэтгэж чадна.

ШҮҮХ ТОГТОЛЦООГ ӨӨРЧЛӨЛТ ГАРГАХАД АШИГЛАХ

Энэтхэгийн Дээд шүүхэд хүний хоол хүнсний эрхийн асуудлыг тавьснаараа Энэтхэгийн Иргэний эрхийн холбоо уг асуудлыг анхаарлын төвд аваачих, олон нийтийн ойлголтыг сайжруулсан. Шүүхээс хоол хүнсний хангамжийн талаар гарч буй хүндрэлд санхүүжилтээс илүүтэйгээр хангамжийн систем нөлөөлж байгааг тогтоосон байна.⁵³ Мөн хүний хүнсний илчлэгийн нормыг тогтоож, хэнийг ч орхигдуулалгүйгээр ядуу нөхцөлд амьдарч буй бүх хүнд хоол хүнс олгох ёстой гэж шийдсэн байна. Үүний зэрэгцээ сурагчдын үдийн хоолны чанар муу, тэгш хүртээмжтэй байж чадахгүй байгааг тогтоож, жилд хамгийн цөөндөө 200 өдөр, хамгийн багадаа 300 калори илчлэг, 8-12 грамм уураг агуулсан өдрийн цай өгөх ёстой гэж шийдвэрлэсэн байна. Мөн шүүхийн шийдвэрийг тухайн орон нутгийн хэл болон англи хэлээр бүх сургууль, хоолны газрууд, нутгийн захиргааны байгууллагууд дээр олон нийтэд хүртэхүйц байдлаар зарлах шийдвэр гаргасан байна.⁵⁵ Уг шийдвэрийг дагаж мөрдөөгүй зарим муж улсад олон нийтийн эсэргүүцэл хүчтэй өрнөсөн байна.⁵⁶ Олон нийтийн шаардлага, хяналтын байгууллагын ажлын үр дүнд уг шийдвэр үр дүнтэй хэрэгжсэн байна. Тооцооноос үзэхэд төрийн мэдлийн хийгээд засгийн газраас дэмжлэг авдаг сургуулиудын 140 сая гаруй сурагч үдийн хоолны хөтөлбөрийн үр ашгийг хүртэж байна.⁵⁷ Үдийн хоолны хөтөлбөр хэрэгжих эхэлснээс хойш охидын сургуульд хамрагдах нь 10 орчим хувиар нэмэгдсэн⁵⁸ бөгөөд бүрэн бус судалгаанаас үзэхэд үдийн цайны хөтөлбөр тус улсын тэн хагасаас илүү нутагт хэрэгжиж, үүний дүнд 350 мянга гаруй охид сургуульд хамрагдсан байна.⁵⁹

Өмнөд Африкт олон нийтийн шүүхэд гаргасан гомдлын дагуу онцгой байдлын үед иргэдийг сууцжуулах сан байгуулсан байна. Мөн иргэдийг хүчээр нүүлгэн шилжүүлэхээс сэргийлсэн шийдвэр гаргуулж чадсан аж.⁶⁰ Мөн эхээс урагт ДОХ-ын халдвар халдахаас сэргийлсэн Невирапин эмийн хэрэглээний талаар гаргасан шийдвэрийг нэг ололт гэж үзэж байгаа юм. Эмийг үйлдвэрлэгч компани эрх мэдэлтнүүдтэй тохиролцон олон нийтэд шууд хэрэглэх шийдвэр гаргуулаад байсан юм. Харин шүүх эмийн хэрэглээг хязгаарлаж зөвхөн туршилтын журмаар багахан хүрээнд хэрэглэх шийд гаргасан. Эмийн үйлдвэрлэгч компани ДЭМБ болон Өмнөд Африкийн Эрүүл мэндийн хяналтын зөвлөлийн дэмжлэгийг⁶¹ авсан хэдий ч шүүх уг эмийг зөвхөн судалгаа шинжилгээний журмаар хэрэглэж болохыг тогтоосон байна. Эмийг хэрэглэснээр урагт ДОХ өвчний халдвар халдахаас сэргийлэх талтай ч шүүх уг эмийг бүрэн шинжилж дуустал зөвхөн хязгаарлагдмал хүрээнд судалгааны зорилгоор хэрэглэж болно гэж шийдсэн байна.⁶² Мөн шүүх засгийн газрыг уг эмийг зөвхөн эмнэлгийн орчинд, шаардлагатай судалгаа шинжилгээг бүрэн хийсний дараа өвчтөнүүдэд хэрэглэх шаардлагыг тавьсан юм.⁶³ Шүүхийн шийдвэр гарсаны дараа олон нийтээс хүчтэй шахалт үзүүлсний дүнд засгийн газар ретровирусыг дарангуйлах эмчилгээ болон эмийн асуудлаар хийх ажлын төлөвлөгөө гаргасан байна.⁶⁴ Энэ бол шүүхийн шийдвэр засгийн газрын бодлогод нөлөөлсөн нэгэн жишээ мөн.

Дээрхи жишээнээс эдийн засгийн болон нийгэм, соёлын эрхийн асуудал дээр шүүх тогтолцоо нааштай өөрчлөлт гаргаж чадахыг харж болно. Эдгээр ололтод хөтөлсөн олон хүчин зүйлсийг дурдаж болно. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалж засгийн газрын дутагдалтай бодлогыг уудлан гаргаж ирсэн шүүхийг дурдаж болох байна. Мөн хүний эдийн засаг, нийгэм соёлын эрхийг тодорхой заасан, түүгээрээ эрх зүйн орчинг үндсийг нь бүрдүүлж өгсөн Өмнөд Африкийн Үндсэн хуулийг дурдаж болно. Үүний зэрэгцээ гаргасан шийдвэрээ хэрэгжүүлж чадсан Энэтхэгийн дээд шүүх, басхүү шүүхэд өөрсдийн зөвийг нотлож чадсан төдийгүй шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх, хяналт тавихад нь нөлөөлж чадсан иргэний нийгмийн байгууллагуудыг дурдах хэрэгтэй.

ОЛОН УЛСЫН ХАРИУЦЛАГЫН МЕХАНИЗМ

Аливаа улс орон хүний эрхийн хэм хэмжээг хангаж ажиллахгүй нөхцөлд олон улсын хариуцлагын механизм чухал үүрэг гүйцэтгэж болох талтай.

Энэ механизмд олон улсын хүний эрхийг хариуцсан байгууллагууд (хяналт тавих болон гомдол хариуцсан⁶⁵ бие даасан экспертүүдээс бүрдсэн), дөрвөн жил тутам үнэлгээ (Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг буюу ХЭТБЭДХ) хийх үүрэгтэй НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөл багтаж байгаа юм.

Харин хүний эрхийн хяналтын систем үүргээ бүрэн биелүүлж хараахан чадахгүй байна. Улс орнууд тайлангаа гаргаж өгөхгүй байх нь түгээмэл байна. Мөн ХЭТБЭДХ-ийн хүрээнд МХЗ-ын хэрэгжилтийг авч хэлэлцэх асуудал тун хангалтгүй байсаар байна.

Дотоодод нь тухайн хүний эрхийн зөрчлийг (Мянганы Хөгжлийн Зорилт болон түүнтэй холбоотой аливаа үйл ажиллагаанаас үүдсэн хүний эрхийн зөрчил) шийдвэрлээгүй нөхцөлд Олон улсын хариуцлагын механизм тэрхүү зөрчилд анхаарлаа хандуулж ажиллах боломж нээлттэй бий. Гэвч энэ нь зөвхөн ЭЗНСЭОУП-ын⁶⁶ болон ЭЯГБХУК-ийн Нэмэлт Протоколд⁶⁷ нэгдэн орсон орнуудад авч хэрэгжүүлэх боломжтой.

НҮБ-ын ЭЗНСЭОУП-ын хороо хөгжиж буй орнуудад тусламж үзүүлэхийг өндөр хөгжилтэй орнуудаас хүссэн. Мөн улс орнууд олон улсын хамтарсан байгууллага түүний дотор, олон улсын санхүүгийн байгууллагуудыг бүрдүүлж ажиллахдаа хүний эрхийн хэм хэмжээг хангах үүрэг амлалтаа чанд сахихыг уриалсан.⁶⁸ Мянганы Хөгжлийн Зорилтын хүрээнд хэрэгжиж буй ажлуудыг ил тод болгож хүний эрхийн хяналтыг хэрэгжүүлэхийн тулд улс орнууд бие даан болон хамтран ажиллах үедээ хүний эрхийн талаар өгсөн амлалтаа биелүүлэх шаардлагатай.

3 ДУГААР БҮЛЭГ: МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТЫН БИЕЛЭЛТЭНД ХҮНИЙ ЭРХ ЯМАР ХАМААРАЛТАЙ ВЭ?

Хүний эрхийн хэм хэмжээг Мянганы Хөгжлийн Зорилтын хүрээнд явуулж буй үйл ажиллагаанд тусгаж чадвал ядуурлыг бууруулахад эерэгээр нөлөөлнө. Энэ бүлэгт жендэрийн тэгш байдал, эхийн эрүүл мэнд болон ядуус гэсэн гурван асуудлаар одоогийн явуулж буй бодлого яагаад хүний эрхийг хангах тал дээр үр дүнд хүрэхгүй байгааг гарган тавих болно. Эмнести Интернэшнлийн зүгээс энэ гурван асуудлыг нэн тэргүүнд тавигдах амин чухал зүйлийн хувьд Мянганы Хөгжлийн Зорилтын хамрах хүрээ болон хүний эрхийн хэм хэмжээ хоёрын ялгааг харуулж чадна гэж үзэж байна. Жендэрийн тэгш байдал болон эмэгтэйчүүдийн эрхийн талаар Мянганы Хөгжлийн Зорилтын үйл ажиллагаа, шалгуур үзүүлэлтүүдэд тусгаагүйгээс үүдэн улс орнууд өөрсдийн бодлого, хууль журам, үйл ажиллагаандаа жендэрийн тэгш байдлыг тусгахгүй байх нь элбэг байна. Эхийн эрүүл мэнд болон төрөлтийн хүндрэлээс сэргийлэх асуудал туйлын хангалтгүй байна. Ядуусын хороололд амьдрагсдын амьдралыг сайжруулах зорилт амжилт олохгүй байгаагийн гол шалтгаан нь ядуусд тулгамдаж буй асуудал, тэдний амьдралыг сайжруулахад чухам ямар ажил хийхээ тодорхой болгож чадаагүйтэй шууд холбоотой.

ХҮНИЙ ЭРХ БОЛОН ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДАЛ

3 ДУГААР ЗОРИЛТ. ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДАЛ ТОГТОХОД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙГ ХҮЧИРХЭГЖҮҮЛЭХ

Зорилго 3.А: 2005 он гэхэд бага дунд сургуульд, 2015 оноос хэтрүүлэлгүйгээр бүх шатны боловсролын тогтолцоонд хүйсийн ялгааг арилгана.

Шалгуур үзүүлэлт:

- 3.1 Бага, дунд, ахлах сургууль дахь хөвгүүд охидын харьцаа
- 3.2 Хөдөө аж ахуйн бус салбаруудад цалинтай ажиллагаа эмэгтэйчүүдийн хувь
- 3.2 Үндэсний парламентад сонгогдсон эмэгтэйчүүд

Мянганы Тунхаглалд “жендэрийн тэгш байдлыг дэмжин эмэгтэйчүүдэд ядуурал, өлсгөлөн, өвчинтэй тэмцэхэд нь дэмжлэг үзүүлж, жинхэнэ тогтвортой хөгжлийн туслалцаа үзүүлнэ”, “эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийг устган, Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийг устгах конвенцийг хэрэгжүүлнэ” гэж тунхагласан.⁶⁹ Гэсэн хэдий ч Мянганы Хөгжлийн Зорилтод эмэгтэйчүүдийн эрхийн бүхий л төвшинд энэ зорилт тусгагдаагүй юм.

Охид, эмэгтэйчүүдийн эрх баталгаатай хангагдсан газар хаа ч байхгүй байна. Эмэгтэйчүүдийг ялгаварлан, эрхийг нь зөрчих, тэдэнд боломж олгохгүй байгаагийн илрэлийг хаанаас ч олж харж болохоор байна. Тооцооноос харахад ядуусын 70 хувь нь

эмэгтэйчүүд байна.⁷⁰ Олон улс оронд эмэгтэйчүүдийн ажил хийх, нийгмийн амьдралд оролцох, эрүүл мэндийн үйлчилгээ авах, хангалттай хоол хүнсээр хангагдах нь эрх нь зөрчигдсөөр байна. Үүн дээр ариун цэвэр, эрүүл ахуйн асуудлыг нэмж хэлж болно. Уугуул иргэдийн болон үндэстний цөөнхийн ядуу амьдралтай эмэгтэйчүүд бүр илүү хүнд нөхцөлд амьдарч байна.

Эрүүл мэндийн түүний дотор бэлгийн, нөхөн үржихүйн үйлчилгээний хомсдолтой байдлаас болж ядуу эмэгтэйчүүдэд хүсээгүй жирэмслэлт, амь насаа алдах аюул тулгарч байна. Эрт гэрлүүлснээс болж охид сурч боловсрох боломжоо алдан төрөлтийн болон жирэмсний хүндрэлээс болж амь насаа алдаж байна.⁷¹ Мөн гэрийн бүхий л ажил охид эмэгтэйчүүдэд оногдсон, цэвэр усны дутагдал, эрүүл ахуйн хангалтгүй байдал зэргээс болж эмэгтэйчүүд олон цагийг ус авчрахад зарж байна. Энэ нь эмэгтэйчүүд өөр ажил эрхлэх, нэн ялангуяа сурч боловсрох нөхцлийг хүндрүүлж байна.⁷² Ядуу буурай орнуудын эмэгтэйчүүд, охид бие засах газар байхгүй учир болж эзгүй газар очих шаардлагатай болдог байна. Үүнээс болж хүчирхийлэлд өртөх нь элбэг болжээ.⁷³

Хэдийгээр ерөнхий боловсрол хүртээх тал дээр зарим ахиц дэвшил гарсан хэдий ч төлөвлөсөн 2005 оноос хойш олон жил өнгөрсөн хэр нь боловсролын салбарт хүйсийн тэгш байдал бүрдэж чадсангүй.⁷⁴ ЮНИСЕФ болон НҮБ-ын Хүүхдийн Сангийн 2007 онд хийсэн тооцооноос үзэх сургуульд хамрагдаагүй 101 сая хүүхдийн дийлэнхи нь охид байна.⁷⁵ Сургуульд хамрагдаж буй охид хөвгүүдийн ялгаатай байдал өнөөг хүртэл байсаар байна.⁷⁶ Дэлхийн уншиж бичиж чаддаггүй 780 сая хүний 3-ны 2 хувь нь мөн эмэгтэйчүүд байна.⁷⁷ Охидын сургуульд хамрагдахгүй байгаа нэг шалтгаан нь сургуулийн орчны эрүүл ахуйн хангалтгүй байдал⁷⁸ болон багш, бусад хүүхдийн гаргадаг хүчирхийлэл, бэлгийн дарамт юм.⁷⁹

Жендэрийн тэгш байдал болон эмэгтэйчүүдийн эрхийг хангах нь ядуурлыг бууруулах болон МХЗ-ыг биелүүлэхэд чухал хүчин зүйл болох нь тодорхой.⁸⁰ Гэтэл энэ бүхэн МХЗ-д тун хангалтгүй тусгагдсан төдийгүй жендэрийн тэгш байдлыг хангах зорилт, түүнийг хэмжих шалгуурууд хязгаарлагдмал бөгөөд хангалтгүй байна.⁸¹ 3 дугаар зорилт ч мөн боловсролын салбар дахь хүйсийн тэгш бус байдлыг халах төдийхнөөр хязгаарлагдаж улс орнуудын эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхахыг устгах амлалтууд нь орхигдсон байна. Энэ нь хоёр үзүүлэлтээр харагдаж байна: Нэгд: хөдөө аж ахуйн бус салбарт цалинтай ажиллаж буй эмэгтэйчүүдийн харьцаа, парламентад эзэлж буй эмэгтэйчүүдийн суудлын тоо, Хоёрт: эхийн эрүүл мэндийг сайжруулах (5 дугаар зорилт). Энэ бүгд улс орнуудын өгсөн амлалттай харьцуулахад тун хангалтгүй байгаа юм. Улс орнууд эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхаж буйд анхаарал хандуулах үүрэгтэй төдийгүй Мянганы Хөгжлийн Зорилтын хүрээнд явуулж буй үйл ажиллагаандаа хүйсийн тэгш байдлыг хангах ёстой. Нэмж хэлэхэд Мянганы Хөгжлийн Зорилтын хүрээнд гарч байгаа ахиц дэвшлийг сааруулж буй жендэрийн эрх тэгш байдалд нийтлэг байгаа саад бэрхшээлүүд Мянганы Хөгжлийн Зорилтын хүрээнд хийх ажилд хангалттай тусгагдаагүй байна.

ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАХ, ЖЕНДЭРИЙН ШИНЖТЭЙ ХҮЧИРХИЙЛЭЛ, БУСАД СААД БЭРХШЭЭЛ

Боловсрол эзэмшсэн эмэгтэйчүүдэд өөрсдийн болоод хүүхдийнхээ эрүүл мэндийг хамгаалах нь боломж нь илүү байдаг. Тэд эрт гэрлэлтээс зайлсхийх болон жирэмслэлтийг зохицуулах, хүүхдүүдээ өсгөж бойжуулах, сурч боловсрох тал дээр боловсрол эзэмшээгүй эмэгтэйчүүдээс илүү чадвартай байдаг байна. Эмэгтэйчүүдийн сурч боловсрох бололцоог сайжруулах нь эх үрсийн эндэгдлийг бууруулах хийгээд Мянганы Хөгжлийн Зорилтыг биелүүлэх чухал хүчин зүйл болно. Охидын сургууль суралцах эрхийг нь эдлүүлэхийн тулд засгийн газрууд нэн түрүүнд сургуулийн орчныг сайжруулах шаардлагатай байна. Үүний тулд сургуулийн орчныг охидод аюулгүй болгож, найдвартай тээврийн хэрэгслээр хангах

хэрэгтэй байна. Мөн охидын ариун цэврийн өрөөг тусад нь гаргаж өгөхийн зэрэгцээ сурч боловсроход саад болж буй бэрхшээлүүдийг (үүнд мөн санхүүгийн бэрхшээл ч орно) арилгах хэрэгтэй байна.

ТАЖИКИСТАН

Тажикистан улсад охидод боловсрол эзэмшүүлэх асуудал тун хүндрэлтэй байна. Хэдийгээр тус улсад 15 нас хүртэл заавал сургуульд суралцах ёстой боловч 13-14 насны охидын 27 хувь нь сургуулиас завсардаж байна. Тус улсад эмэгтэйчүүдийн тухайд гэрийн эзэгтэйн л үүрэгтэй гэж үзэх нь түгээмэл байгаа учраас олонхи гэр бүл охидынхоо боловсролд анхаардаггүй байна. Хөвгүүдийг гэр бүл нь сурч боловсрохыг дэмжээд харин охидыг гэрлэх хүртэл нь гэрийн ажил хийлгэх нь түгээмэл байна. Мөн олон айл сургуульд сурахад гарах хэрэглээний зардлыг гаргах боломжгүй байдаг учраас охидоо хайхралгүй орхиод хөвгүүдээ сурч боловсрохыг илүүд үздэг байна. Хичээлийн агуулга нь хуучирсан, багш нарын цалин хангалтгүй, чадвар муу, төсөв санхүүжилт хангалтгүй зэргээс болж Тажикистаны боловсролын систем гүнзгий хямралд нэрвэгдсэн юм.⁸³

Хүйсийн ялгаатай байдлаас үүдэлтэй эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн олон хэлбэр байна. Охидын амийг хороох, бэлгийн хүчирхийлэл, доромжлох, хүчээр болон бага насанд нь гэрлүүлэх, ажлын байран дахь бэлгийн дарамт, хүчил цацах, хулгайлах, хүчээр биеийг нь үнэлүүлэх, үргүйдүүлэх зэрэг олон хэлбэрийн хүчирхийлэл гарч байна.⁸⁴ Олон улсын хууль журмын дагуу засгийн газрууд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн хэргийг мөрдөн байцааж, шийтгэл хүлээлгэхийн зэрэгцээ ийм хүчирхийлэл гарахаас хамгаалах үүрэгтэй. Үүний тулд хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдэд хууль сахиулах байгууллагуудад хандах боломжийг олгож, хохирлыг барагдуулах шаардлагатай.⁸⁵

Канадын уугуул эмэгтэйчүүд тус улсад нийтлэг болсон арьс өнгөөр ялгаварлах үзэл, ядуурал болон гадуурхалаас болж бусад улс орны эмэгтэйчүүдээс илүүтэйгээр хүчирхийлэлд өртөж байна.⁸⁶ Ялгаварлан гадуурхалаас болж уугуул эмэгтэйчүүд засгийн газрын үйлчилгээг авч чадахгүй байна. Үүнээс үүдэн амьжиргааны түвшингийн ялгаа асар их болжээ. Уугуул эмэгтэйчүүдэд үйлчилгээ үзүүлэхээс татгалзах тохиолдол олонтоо гардаг байна. Мөн хууль сахиулах байгууллагууд хүсэлтийг нь ойшоож үздэггүйгээс уугуул эмэгтэйчүүдийн эсрэг үйлдсэн хэрэг шүүхээр шийдэгдсэн нь тоотой хэдхэн байдаг байна.⁸⁷

Хүний эрхийн төлөө тэмцэгч эмэгтэйчүүдийг хамгаалах байдал сул, халдагчдыг тэр болгон шийтгэдэггүйгээс хүний эрхийн төлөө тэмцэгчид идэвхитэй ажиллахад хүндрэлтэй байна. Эрхийнхээ төлөө тэмцэгч эмэгтэйчүүд явуулсан үйл ажиллагааныхаа төлөө халдлага, дарамтанд өртөх тохиолдол олон гарч байна.⁸⁸ Афганистанд хүчирхийллийн хэргийн талаар гомдол гаргах, хоргодох байраар хангах, хүчээр хүнтэй суулгахаас сэргийлэх, боловсролын болоод гэр бүл төлөвлөлтийн зөвлөгөө өгөх зэрэг үйл ажиллагаа явуулж байгаа эмэгтэй хүний эрхийн төлөө тэмцэгчид Талибан болон засгийн газрын эсрэг бүлгүүдийн заналхийлэлд өртөж амь насаа алдах, нутгаасаа дүрвэсэн удаа олон гарлаа.⁸⁹

Мянганы Хөгжлийн Зорилтод эмэгтэйчүүдийн эрхийн асуудал бүрэн тусгагдаагүй нь улс орнууд МХЗ-ын үйл ажиллагаандаа тэгш бус байдал болон ялгаварлан гадуурхалтанд өртсөн эмэгтэйчүүдийн эрхийг орхигдуулах нэг үндэс болж байна.⁹⁰ Мөн Мянганы Хөгжлийн Зорилтын үйл ажиллагааны мэдээллийн хангалтгүй байдал нь хүйсийн болон бусад ялгаварлан гадуурхлыг үл ойшооход нөлөөлж байна.⁹¹

3 дугаар зорилт нь зарим чухал асуудлыг тусгасан хэдий ч бусад нэн чухал олон зүйлсийг орхигдуулсан юм. Энд эмэгтэйчүүдийн эрх хуулинд тэгш бус тусгагдаж байгааг дурдаж болно. Үүнээс үүдэн эмэгтэйчүүдийн иргэний эрхийн, байцаан шийтгэх, хувийн эрхийн тухай, эд хөрөнгийн эрхийн, улс төрийн болон ажил эрхлэх эрх зөрчигдөж саад бэрхшээлтэй тулгарч байна.

ХҮНИЙ ЭРХИЙН ХЭМ ХЭМЖЭЭГ ХАНГАХ НЬ

Засгийн газрууд олон улсын хүний эрхийн хууль журмын дагуу гаргасан үүрэг амлалтаа биелүүлэхийн тулд:

- Мянганы Хөгжлийн Зорилтын хүрээнд явуулж буй ажиллагаандаа хүйсээр ялгаварлан гадуурхах асуудалд анхаарлаа хандуулах, жендэрийн асуудалд хэрхэн хандаж буй талаараа дэлгэрэнгүй мэдээлэл гаргах,
- Ядуурлыг бууруулах аливаа бодлого, төлөвлөгөө, үйл ажиллагаандаа эмэгтэйчүүдийн эрхийн асуудлыг анхааралдаа авч эмэгтэйчүүдэд тулгарч буй саад бэрхшээлийг арилгах,
- Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхаж буй хууль журмыг халж, эмэгтэйчүүдийг дорд үзсэн уламжлалт хандлага, зан заншилд анхаарлаа хандуулах,
- Хүйсийн шинжтэй хүчирхийлэлтэй тэмцэх шаардлагатай бүх арга хэмжээг авч хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийг хууль сахиулах байгууллагад хандах боломжоор хангаж, тэдэнд туслалцаа үзүүлэх,
- Эмэгтэйчүүдийг шийдвэр гаргах түвшинд оролцох боломжийг хангах, эмэгтэйчүүдийн эрхийн төлөө тэмцэгчдийг хамгаалж, үйл ажиллагааг нь дэмжих хэрэгтэй байна.

ЭХИЙН ЭРҮҮЛ МЭНД БА ХҮНИЙ ЭРХ

ЗОРИЛТ 5: ЭХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙГ САЙЖРУУЛАХ

Зорилго 5.А: Нөхөн үржихүйн эрүүл мэндийн шаардлагатай тусламж үйлчилгээг хүн бүрт хүргэж, эхийн эндэгдлийг 1990 онтой харьцуулахад 2015 онд гуравны хоёр хувиар бууруулах,

Зорилго 5.Б: 2015 он гэхэд нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээг бүх эхэд хүргэх,

Шалгуур үзүүлэлт:

- 5.1 Эхийн эндэгдлийн түвшин
- 5.2 Мэргэжлийн эмчийн эх барьж авсан төрөлтийн хувь
- 5.3 Жирэмслэлтээс сэргийлэх мэдлэг эзэмшсэн хувь
- 5.4 Өсвөр насныхны жирэмслэлтийн хувь
- 5.5 Төрөлтийн өмнөх халамж үйлчилгээ
- 5.6 Гэр бүл төлөвлөлт

Судалгаанаас⁹² харахад эхийн эрүүл мэндийн асуудалд зарим нэг ахиц гарч буй хэдий ч 2015 онд төлөвлөсөн зорилтын тун бага хувь биелэхээр байна.

Мэдэгдэж буйгаар минут тутамд нэг эх жирэмсний болон төрөлтийн хүндрэлээр амь насаа алдаж байна. Харин жил тутам 10-15 сая эх жирэмслэлтийн хүндрэлээс болж өвчин эмгэгт өртөж байна.⁹³ Жирэмсний хүндрэлд өртсөн эхчүүд удаан хугацаанд би сэтгэлзүйн зовиурт автаж, нийгэм эдийн засгийн хүндрэлтэй нөхцөлд амьдрах болдог байна. Төлөвлөөгүй болон хүсээгүй жирэмслэлт, жирэмслэлтээс хамгаалах мэдлэг муу, гэр бүл төлөвлөлтийн мэдлэг дутуугаас болж эхчүүд аюултай үр хөндөлт хийлгэн амь насаа алдах, эрүүл мэндээрээ хохирох аюулд өртөх нь элбэг байна.

НҮБ-ын Хүн Амын Сангийн мэдээлснээр жирэмсний хүндрэлээр нас барсан эмэгтэйчүүдийн 99 хувь нь хөгжиж буй орны эмэгтэйчүүд байна.⁹⁴ Хөгжиж буй орнуудад 15-аас 19 насны охидын эндэгдэлд жирэмсний хүндрэл хамгийн өндөр хувьтай байна.⁹⁵ Цус алдалт, халдвар авах, цус багадалт, хүнд хүчир ажил эрхлэх, аюултай нөхцөлд хийсэн үр хөндөлт зэрэг нь төрөлтийн хүндрэлээр эндэх дийлэнхи шалтгаанууд болж байна. Жил бүр 68000 эмэгтэйчүүд үр хөндөлтөөс болж нас барж байна.⁹⁶

Бага насны охидын жирэмслэлт, төрөлтөөс үүдсэн эндэгдэл маш хурдацтай нэмэгдэж байна. 20-оос дээш насныхныг бодоход 15 хүртэлх насныхан 5 дахин их, 15-аас 20 хүртэлх насныхан 2 дахин ихээр эндэж байна.⁹⁷ Аюултай орчинд үр хөндүүлж буй эмэгтэйчүүдийн 4/1 хувь нь 15-19 насны охид байна. Энэ нь жилд 5 сая үр хөндөлт хийлгэж байна гэсэн үг юм.⁹⁸

Төрөлтийн хүндрэлээр нас барах, сэтгэл зүйн эмгэгт өртөх нь улс орнуудыг харьцуулж үзвэл маш ялгаатай байна. Ядуурал, ялгаварлан гадуурхах, үл ойшоох зэргээс болж эмэгтэйчүүд янз бүрийн хэмжээгээр аюулд өртөж байна. Перу улсад сэргийлж болох төрөлтийн хүндрэлээр нас барсан эмэгтэйчүүдийн дийлэнхи нь хөдөөний болон уугуул эмэгтэйчүүд байна.⁹⁹ АНУ-д төрөлтийн хүндрэлээр нас барсан эмэгтэйчүүд Грек улсаас 5 дахин, Германаас 4 дахин, Испаниас 3 дахин их байна.¹⁰⁰ АНУ-ын Африк гаралтай эмэгтэйчүүд цагаан арьстан эмэгтэйчүүдээс төрөлтийн хүндрэлээр 4 дахин их нас барж байна.¹⁰¹

ЗОРИЛТ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Мянганы Хөгжлийн 5 дугаар зорилтын хамрах хүрээ, зорилго, шалгуур үзүүлэлтүүдэд сэргийлж болох төрөлтийн хүндрэлээр өвдөх, нас баралтын жинхэнэ шалтгаануудыг хөндөж чадаагүй юм. Бага насанд, хүчээр гэрлүүлэх хийгээд эмэгтэйчүүд охидын эсрэг хүчирхийлэл, ялгаварлан гадуурхах болон ядуурлаас болж эмэгтэйчүүдийн бэлгийн болон нөхөн үржэхүйн эрхийг хязгаарлаж буй болон эмэгтэйчүүдийн өөрсдийн эрүүл мэнд, амьдралд өөрсдөө шийдвэр гаргахад ямар хүндрэл учирч бай талаар 5 дугаар зорилтод орхигдуулсан юм. Эхийн эндэгдлийг бууруулахын тулд эдгээр асуудлыг системтэйгээр, нягт нямбай авч үзэх шаардлагатай байна.

5 дугаар зорилтын 2 зорилго, түүний шалгуур үзүүлэлтэнд төрөлтийн болон төрөлтийн дараах үйлчилгээг мэргэжсэн эмнэлгийн ажилтнуудаас авах, гэр бүл төлөвлөлтийн мэдээлэлтэй болох, өсвөр насны болон хүсээгүй жирэмслэлтээс сэргийлэх талаар сайтар тусгаж өгөх шаардлагатай ч хангалттай тусгагдаагүй байна. Төрөлтийн хүндрэл өндөр хувьтай байдаг орнуудын мэдээлэл хангалтгүйгээс болж тулгарч буй аюулын талаар буруу зөрүү ойлголт газар аваад байна. Мэдээллийг дэлгэрэнгүй гаргаж өгөх шаардлага тавихгүй байгаагаас болж хамгийн их орхигдож гадуурхагдсан зах хязгаар нутгийн, ядуу, уугуул, бага насны эмэгтэйчүүд охидын эндэгдлийг бууруулах ажил орхигдоод байна. Хэдийгээр мэргэжсэн эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх асуудлыг шалгуур үзүүлэлт болгон авч үзэх нь зүйтэй ч үйлчилгээний чанар, хүртээмжийн асуудлыг мөн л орхигдуулсан байна.¹⁰²

БЭЛГИЙН БОЛОН НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРХ

Мянганы Хөгжлийн 5 дугаар зорилт нь эхийн эрүүл мэндийн хамгийн чухал хэрэгцээ шаардлагыг гарган тавьсан. Гэсэн хэдий ч үйл ажиллагаагаа тун хязгаарлагдмал байдлаар төлөвлөсөн юм. Ердөө л эмнэлгийн үйлчилгээ авах боломжийг сайжруулах, улс орнуудын өмнө нь амлалт өгч үүрэг авсан эмэгтэйчүүдийн эрхийг (үүнд бэлгийн болон нөхөн үржихүйн эрхийн асуудлууд мөн багтаж байгаа) дэмжих амлалтын хүрээнд үйл ажиллагаа явуулах зорилт тавьсан. Эдгээр эрх нь НҮБ-ын Эмэгтэйчүүдийн асуудлаарх IY бага хурлын үеэр баталсан Үйл Ажиллагааны Зарчим, Олон Улсын Хүн Ам, Хөгжлийн Бага Хурлын үеэр баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө болон 186 орон нэгдэн орсон ЭЯГБХУК-д тусгагдсан билээ.¹⁰³

Эмэгтэйчүүдийн өөрсдийн нөхөн үржихүйн болон бэлгийн амьдралтай холбоотой аливаа асуудалд өөрсдөө шийдвэр гаргаж байж л бэлгийн болон нөхөн үржихүйн эрх хэрэгжих боломжтой болно. Энэ нь эмэгтэйчүүд бэлгийн амьдралаа өөрсдөө шийдэж, гэр бүл болох, хүүхэд төрүүлэх тал дээр бие даан шийдвэр гаргах, аюултай орчинд үр хөндүүлэх, хүйсийн хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэл хийгээд алив хортой нөхцөлөөс ангид байх зэрэг асуудлууд мөн хөндөгдөж байгаа хэрэг юм.¹⁰⁴ Эмэгтэйчүүдийн эрхийг бодитоор хэрэгжүүлэхэд мөн боловсролын эрх, хүнс хоол, эрүүл мэнд, түүнтэй холбоотой бусад хүчин зүйлсийн стандартыг хэрэгжүүлж сахих, хуулийн өмнө эрх тэгш байх асуудлууд ч мөн адил хамаатай юм.

5 дугаар зорилт нь хөгжил дэвшил гаргахад амин чухал нөлөөтэй хоёр ч зүйлийг орхигдуулсан юм. Нэгд: эрүүл мэндийн үйлчилгээг бүгдэд хүртээмжтэй, ёс зан заншилд нь нийцтэйгээр, ялгаварлалгүйгээр хамгийн эмзэг, орхигдсон эмэгтэйчүүдэд хүргэх асуудлыг орхигдуулсан байна. Хоёрт: эмэгтэйчүүд охидыг жирэмсний болон төрөлтийн хүндрэлээр нас барах, хүсээгүй жирэмслэлтээс үүдэн гарч ирдэг аливаа хүндрэлийн шалтгаануудыг хайхралгүй орхисон байна.

НИКАРАГУА – АМЬД ЯВАХ, ЭРҮҮЛ БАЙХ ЭРХИЙГ НЬ ЗӨРЧИЖ БАЙНА

2008 оны 7 дугаар сараас эхлэн үр хөндөлтийг хориглож, гэмт хэрэг болгон зарласан байна. Тус улсын шинэчилсэн эрүүгийн байцаан шийтгэх хуулинд зааснаар ямар ч шалтгаантай байсан хамаагүй үр хөндөлт хийлгэсэн болон үр хөндөлт хийлгэх оролдлого хийсэн эмэгтэйчүүд, охидыг шийтгэхээр болсон. Мөн эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудыг хүндялаар шийтгэхээр заасан байна. Энэ нь тус улсын Эрүүл мэндийн яамнаас гаргасан Эх барих журамтай (энэхүү журамд шаардлагатай тохиолдолд эмнэлгийн байгууллага үр хөндөлт хийж болно гэж заасан байна) зөрчилдөж байгаа хэрэг бөгөөд эмнэлгийн байгууллагын ажилтнуудыг маш хүнд байдалд оруулаад байна.

Энэ хууль болоод хүүхдээ цаашид үргэлжлүүлэн тээвэл ноцтой үр дагаварт хүрч болох эмэгтэйчүүд, охидыг аюулд учруулаад байна. Нэн ялангуяа амь насанд нь халтай өвчний эмчилгээ хийлгэж байгаа, зулбасан болон үр хөндүүлсний дараа эмчилгээ хийлгэх шаардлагатай, бэлгийн хүчирхийлэл өртөх буюу ойр төрлийн хүнээсээ бие давхар болсон эмэгтэйчүүд, охидод маш бэрхшээлтэй байдал үүсээд байна. Тус улсад бэлгийн хүчирхийлэлд өртөж жирэмсэлсэн охид эмэгтэйчүүдийн дийлэнхи нь 10-14 насны охид байгаа бөгөөд аюултай орчинд үр хөндүүлэх болон хэт бага насандаа хүүхэд төрүүлж байгаагаас тэдний амь нас, эрүүл мэндэд ноцтой аюул тулгарч байна. Бэлгийн хүчирхийлэлд өртөөд хууль бусаар, аюултай орчинд үр хөндөлт хийлгэхээр завдсан эмэгтэйчүүд, тэдэнд тусалсан хүмүүс бүгд шоронд хоригдох аюулд өртөөд байгаа юм.

НҮБ-ын 4 байгууллага Никарагуа улсын энэхүү хууль нь тус улсын олон улсын өмнө хүлээсэн үүрэгтэй нь харшилж буйг тогтоосон.

Никарагуа улс 2015 он гэхэд эхийн эндэгдлийг 75 хувь бууруулах амлалт өгсөн. Тус улсын засгийн газар эхийн эндэгдлийг бууруулах зорилгоор олон тооны хөтөлбөр хэрэгжүүлж эрүүл мэндийн салбарын санхүүжилтийг нэмсэн. Харин үр хөндөлтийг гэмт хэрэг гэж үзэж байгаа нь энэ бүх хийж буй ажилтай нь зөрчилдөж байгаа юм. Тус улс Мянганы Хөгжлийн 5 дугаар зорилтыг бүр мөсөн орхигдуулаад 3 дугаар зорилтыг “биелүүлэх” ойлгомжгүй байдал үүсээд байна.

ТӨРӨЛТИЙН ХҮНДРЭЛД НӨЛӨӨ ҮЗҮҮЛЖ БҮЙ ХҮЧИН ЗҮЙЛС

Засгийн газрууд эрүүл мэндийн чанартай үйлчилгээг бүх хүмүүст ялгаварлан гадуурхалгүйгээр хүргэх үүрэгтэй. Гэсэн хэдий ч жирэмсэн эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн үйлчилгээнд хүндрэл оршсоор л байна.

Перу улсад уугуул, хөдөөний, ядуу эмэгтэйчүүдийн жирэмсний эрүүл мэндийн үйлчилгээ авахад нь гүн суурьтай ялгаварлан гадуурхалтаас үүдэлтэй олон бэрхшээл тулгарч байна. Зарим эхчүүд биеийн байцаалт, бичиг баримтгүйгээсээ болж төлбөргүй эрүүл мэндийн үйлчилгээг авч чаддаггүй байна. Мөн эрүүл мэндийн үйлчилгээний мэдлэг дутмаг, эрүүл мэндийн байгууллагуудаас хол амьдрах, тээврийн хөлс төлөх чадваргүй, эрүүл мэндийн байгууллагуудын ялгаварлан гадуурхах хандлага, эх барих арга нь уламжлалт зан заншилд нийцдэггүй, хэлний бэрхшээл зэргийг энд дурдаж болно.

2006 оноос хойш Перугийн засгийн газар эдгээр асуудлыг шийдэх зарим арга хэмжээ авсан. Эх барих уламжлалт аргыг нь зөвшөөрсөн, эхчүүдийн хүлээлгийн өрөөний тоог нэмсэн, хөдөөний иргэдийн эрүүл мэндийн даатгалд дэмжлэг үзүүлэх төсөв, хөрөнгийн асуудлыг шийдсэн зэргийг энд дурдаж болно. Гэсэн хэдий ч зайдуу амьдардаг болон уугуул үндэсний эхчүүд шаардлагатай халамж үйлчилгээ авахад бэрхшээлтэй тулгарсаар байна. Гол гарч буй бэрхшээл нь засгийн газрын бодлогын хэрэгжилтийг хянах тал дээр дутмаг хийгээд үүрэг, хариуцлагын асуудал тодорхой бус байгаад оршиж байна. Хэрэв Перу улс уугуул эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн үйлчилгээний дутагдлыг залруулахгүй бол Мянганы Хөгжлийн 5 дугаар зорилт биелэх боломжгүй болж ялгаварлан гадуурхах асуудал хэвээр үргэлжилэх хандлагатай байна.

Сьерра Леон болон Буркина Фасо улсууд төрөлтийн эрүүл мэндийн асуудлыг анхааралдаа авч зарим нааштай арга хэмжээ авч байна. Гэхдээ мөн адил сэргийлж болох эхийн эндэгдэлд маш их нөлөөлж буй хүйсээр ялгаварлан гадуурхах, эрт гэрлүүлэх, хэт эрт жирэмсэн болох, эмэгтэйчүүдийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрхийг үгүйсгэх, эмэгтэйчүүдийн нийгмийн статусыг дорд үзэх (гэр оронд нь болон нийгмийн түвшинд), шийдвэр гаргах боломжгүй байгаа зэрэгт анхаарал хандуулсангүй.

Сьерра Леоний эмэгтэйчүүд эмнэлгийн байгууллагууд хол байрласан болон эмчилгээний чанар хангалтгүй зэргээс болж олон тооны бэрхшээлтэй тулгарч байна. Буркина Фасод эмнэлгийн үйлчилгээний өндөр төлбөр сэргийлж болох эхийн эндэгдлийн гол шалтгаан болж байна. Эмнести Интернэшнлийн урьдчилан сэргийлж болох эхийн эндэгдлийг бууруулах уриалгад нааштай хандаж жирэмсэн эхчүүдэд тулгарч буй санхүүгийн бэрхшээлийг шийдвэрлэх амлалт өгч Сьерра Леон улс саяхан жирэмсэн эхчүүд болон 5 хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн үйлчилгээг төлбөргүй болгох шийдвэр гаргалаа. Буркино Фасо, Сьерра Леон улсууд энэхүү үйл ажлаа бүрэн хэрэгжүүлбэл эмэгтэйчүүд эмнэлгийн үйлчилгээ авахад тун чухал алхам болно. Гэхдээ эмэгтэйчүүдийн эсрэг, бэлгийн болон нөхөн үржихүйн эрхийн эсрэг архагшсан зөрчлийг системтэйгээр шийдэж байж л эхийн эрүүл мэндийн асуудалд тогтвортой амжилт гарах юм.

Өндөр хөгжилтэй болон хөгжиж буй орнуудад их бага ямар нэг хэмжээгээр эхийн эрүүл мэндийн үйлчилгээний тулгамдсан асуудал хадгалагдсаар байна. АНУ-д хоног бүр 2-оос багагүй эмэгтэйчүүд жирэмсний юмуу төрөлтийн хүндрэлээр амь насаа алдаж байна. Хэрэв тус улсад бүх эхэд эхийн эрүүл мэндийн үйлчилгээг ялгаварлан гадуурхахгүйгээр үзүүлдэг байсан бол эхийн эндэгдлийг тал хувиар бууруулж болох байсан. Төлбөрийн чадвартай л бол АНУ дэлхийд эрүүл мэндийн үйлчилгээг хамгийн сайн үзүүлж чадна. Гэхдээ олонхийн хувьд энэ үйлчилгээ хүртээлгүй байдаг. Хэдийгээр эхийн эрүүл мэндэд асар их хөрөнгө зарж буй хэдий ч бага орлоготой эмэгтэйчүүдэд эрүүл мэндийн үйлчилгээ авахад олон тооны бэрхшээл тулгардаг байна. Засгийн газраас санхүүжилтийг нь гаргадаг эрүүл мэндийн даатгалаас үйлчилгээ үзүүлсэн төлбөр буцаан авахад гардаг хүндрэлээс болж эмч нар бага орлоготой эмэгтэйчүүдэд анхаарал тавих сонирхолгүй байдаг. Эрүүл мэндийн үйлчилгээ авах хийгээд эрүүл мэндийн үйлчилгээний үр дүн мэдэгдэхүйц ялгаатай байна. 2008 оны судалгаагаар 46 сая буюу 6 хүний нэг нь эрүүл мэндийн ямар ч даатгалгүй байгаа нь тодорхой болсон. Эдийн засгийн хямралаас хойш эдгээр хүний тоо улам нэмэгдсэн. Үндэсний цөөнхи хүн амын 34 хувийг эзэлдэг хэдий ч эрүүл мэндийн даатгалгүй хүмүүсийн талаас илүү хувийг үндэсний цөөнх иргэд эзэлж байна. Үүнээс үүдэн жирэмсний үеийн эрүүл мэндийн эрсдэлтэй байдалд илүү ихээр өртөж байна.

ОРОЛЦООНЫ АСУУДАЛ

Эрүүл байх эрхийн нэгэн хэсэг нь иргэдийн өөрсдийн оролцоо мөн. Иргэд өөрсдийн оролцооны эрхээ эдэлж байж л хувийн болон нийгмийн чанартай асуудалд, нэн ялангуяа эрүүл мэндийн аливаа асуудлуудад шийдвэр гаргах түвшинд оролцох боломж нь нээгдэнэ. Оролцооны эрхээ эдлэх нь эрүүл мэндийн системийг хүмүүсийн эрэлт хэрэгцээнд нийцсэн түвшинд хүргэх нэг хүчин зүйл болно. Үүнийг Балба улсын жишээнээс харж болно. Тус улсад төрөлтийн сургалтанд суусан зах хязгаар уулархаг нутгийн эмэгтэйчүүд бусдыгаа бодоход төрөлтийн үеэр эрүүл мэнддээ хамаагүй илүү анхаарал тавьж буйг олж харж болно. Эдгээр эмэгтэйчүүд эрүүл мэндийн байгууллагын мэргэжлийн үйлчилгээг эрүүл аюулгүй орчинд авч байх хэрэгтэйг бүрэн ойлгосон юм.¹¹⁴

“Бид бүгд өөрсдийн эрүүл мэндэд холбоотой асуудлаар мэдээлэлтэй байж идэвхитэй оролцох эрхтэй. Олон нийтийн оролцоо ямар чухал үүрэг гүйцэтгэх ёстой Алма Атагийн тунхаглалд олонтаа дурдсан. Хамгийн чухал улс орнууд олон нийтийн, иргэдийн идэвхитэй бөгөөд мэдээлэлтэй оролцох боломжийг хангаж өгөх хэрэгтэй байна.

“Пол Хант, НҮБ-ын эрүүл мэндийн асуудлаархи Тусгай илтгэгч, 2008 он.”¹¹⁵

ХҮНИЙ ЭРХИЙН ХЭМ ХЭМЖЭЭГ ХАНГАХ НЬ

Засгийн газрууд Мянганы Хөгжлийн 5 дугаар зорилтыг биелүүлж, олон улсын хүний эрхийн хуулийн дагуу өгсөн амлалтаа хэрэгжүүлэхийн тулд:

- Эмэгтэйчүүдийн эрүүл байх эрхийг бүрэн эдлүүлэхийн тулд эмэгтэйчүүдийн эрхийг зөрчиж болзошгүй аливаа үйл ажиллагаанаас сэргийлэх хэрэгтэй байгаа бөгөөд зарим улс орон нөхөр, эсвэл хамтран амьдрагчийг нь заавал цуг байлцуулж байж бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлнэ гэсэн шаардлага тавьж байна. Эдгээр хориг саадыг арилгаж эмэгтэйчүүд нөхөр эсвэл хамтран амьдрагч төдийгүй эцэг эх болон эрүүл мэндийн байгууллагын албан тушаалтнаас ямар нэг хамааралгүйгээр эрүүл мэндийн үйлчилгээ авах боломжийг хангаж өгөх.¹¹⁶
- Эмэгтэйчүүдийн эрхийг хөндлөнгийн этгээдийн нөлөөнөөс хамгаалах, бэлгийн болон нөхөн үржихүйн эрхээ эдлэхэд нь саад хориг болж болох нийгмийн болон уламжлалт зан заншил, олон нийтийн хандлагаас хамгаалах.¹¹⁷
- Эрүүл байх эрхийг бүрэн хэрэгжүүлэхийн тулд шаардлагатай арга хэмжээг авах, хүнд эрүүл мэндийн үйлчилгээ авахад саад болж буй бэрхшээл, нэн түрүүнд санхүүгийн бэрхшээлийг арилгаж эмэгтэйчүүдэд шаардлагатай эрүүл мэндийн (онцгойлон эх барих халамж үйлчилгээг дурдаж болно) үйлчилгээгээ хүндрэл бэрхшээлгүйгээр авах боломжийг гаргаж өгөх.¹¹⁸
- Хууль журам, баримталж буй бодлогод оршиж буй хүйсээр ялгаварлах шинжтэй, нэн ялангуяа эмэгтэйчүүдийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрхтэй холбоотой асуудлуудыг олж тогтоон эмэгтэйчүүд, охидыг хүчээр болон бага насанд нь гэрлүүлэх, аюултай үр хөндөлт хийлгэх болон эмэгтэйчүүдийн эсрэг бүх хэлбэрийн хүчирхийлэлтэй тэмцэх.
- Эмэгтэйчүүдийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрхийг зөрчих, хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн бие сэтгэлийн зовиурыг анагаах асуудалд анхаарлаа хандуулж, хариуцлага тооцох талаар анхаарал хандуулах, хүний тулд эхийн эндэгдэл, мөн ялгаагүй төрөлтийн хүндрэлүүдэд хяналт, шалгалт хийх механизм хэрэгтэй байна. Мөн эрүүл мэндийн үйлчилгээ авч чадаагүй эмэгтэйчүүдийн гомдол гаргах механизмыг бүрдүүлж, хүний эрхийнхэм хэмжээг хянах бие даасан институт¹¹⁹ бий болгох шаардлагатай байна.



Дээрх зураг: 2004 он Энэтхэг улс, Кальутта хот Ядуусын хорооллын болон гудамжинд хоноглодог эмэгтэйчүүд жирэмсний хяналтын хичээлд сууж буй нь.

Баруун зураг: Цыган иргэдийн амьдардаг төмөр контейнерууд. Румын, Миеркуриа Чиук/Цикцередагийн Харгита дүүрэг, 2009 оны 1 дүгээр сар.





Дээрх зураг: Яки Аксагийн суугчид Позо Колорадо-Концептион хурдны замын хажууд хөлбөмбөг тоглож буй нь. Парагвай улс,

2008 оны 11 дүгээр сар. Яки Акса болон Сахоямасагийн уугуул иргэд 20 жил нийгмийн үйлчилгээнээс тусгаарлагдсан орчинд хурдны зам дагуу амьдарч байна. Хэдий Америк тивийн хүний эрхийн шүүх нилээд хугацааны өмнө тэдний талд шийдвэр гаргасан хэдий ч одоог хүртэл эдгээр иргэд уугуул нутгийг нь тэдэнд буцааж өгөхийг хүлээсээр байна.

Доорх зураг: Эмэгтэй хуульчдын холбооноос явуулж буй хүний эрхийн сургалтанд сууж буй Тажик эмэгтэйчүүд. 2009 оны 7 дугаар сар. Тажик охидод сурч боловсрох эрхээ эдлэхэд нь олон саад бэрхшээл тулгардаг байна.



Эхийн эндэгдлийг бууруулах Эмнести
Интернэшнлийн кампанит ажлын
нээлт, 2009 оны 9 дүгээр сар, Сьерра
Леон улс. Сьерра Леон улс эхийн
эндэгдлээр дэлхийд хамгийн өндөр
улсуудын нэг юм.



Баруун зураг: Нутгийн иргэд чулууны нуралтаас үүдсэн олон тооны байшингийн нурангиас амьд үлдэгсдийг гаргахаар хичээж байна. Египет, Кайр хот, хотын захын зөвшөөрөлгүй суурин, 2008 оны 9 дүгээр сарын 6. Том хад чулуу нурж, 100 гаруй хүн амь үрэгдэж, олон байшин сүйдсэн байна.

Доорх зураг: Төмөр замын дагуух зах. Кени, Найроби хотын Киберагийн ядуусын хороолол, 2009 оны 2 дугаар сар. Албадан нүүлгэснээс болж Кенийн энгийн иргэд байр сууц, амьжиргаагаа алдаж улам ядуурч байна. Засгийн газраас явуулж буй Найроби голыг цэвэрлэх хөтөлбөрөөс болж Киберагийн ядуусын хорооллын хэд хэдэн зах хаагдахад хүрээд байна.





Дээрх зураг: Эрүүл мэндийн төвийн гадна хүлээж буй эмэгтэйчүүд, Хаункавелика дүүргийн Сан Хуан Де Чархуач, 2008 он 9 дүгээр сар. Перу улсад ядуу болон зах хязгаар нутгийн уугуул эмэгтэйчүүдийн дунд төрөлтийн хүндрэл харьцангуй өндөр байдаг байна.

Баруун зураг: Палестин тосгон Сусягийн нийтийн бие засах газар, Палестиний нутаг дэвсгэр. 2008 оны 5 дугаар сар. Израйлийн арми энэ хэсгийг чөлөөлөх ажиллагаа явуулах магадлалтай байгаа. Израйлийн засгийн газрын хатуу бодлогоос болж урт хугацаанд энэ хэсэг нутаг цэвэр усны хомсдолд нэрвэгдээд байна. 200 орчин мянган Палестин иргэн ундны усны хомсдолд оржээ.

Баруун зураг: Йемен эмэгтэйчүүд хуурай суваг дээгүүр гарч байна. Йемений нийслэл Сана'а хот, 2010 оны 3 дугаар сар. Йемен улс хүн амын хурдацтай өсөлт, бороо багассанаас болж ундны усны хомсдолд нэрвэгдээд байна. 10 жилийн дараа нийслэлийн усан сангууд усгүй болж хатна гэсэн тооцоог засгийн газар хийсэн бөгөөд ус авахын тулд эмэгтэйчүүд хотоос хол зайтай байдаг худаг руу явах болдог байна. Шөнө оройн хүйтэн, олон километрийн хол усанд явах нь эмэгтэйчүүдэд тулгарч буй хүнд асуудал болоод байна.



Доорх зураг: Шударга ёсыг шаардаж буй Уугуул эмэгтэйчүүд, тэднийг дэмжигчдийн тэмцэл, 2008 он. Тэд Ванкувераас Оттава хүртэл 3500 километр газар алхаж ирсэн бөгөөд Канадын уугуул эмэгтэйчүүд бусад эмэгтэйчүүдээс хамаагүй илүүтэй хүчирхийлэлд өртдөг байна. Урхагшсан арьс өнгөөр ялгаварлах үзлээс болж уугуул иргэдийн амьдралын нөхцөл улам хүндэрч хүчирхийлэлд өртөх эрсдэл нэмэгдсээр байна.





Дээрх зураг: Буркина Фасогийн Накамбе голын эрэг дээр Раматулэй охиноо тэврэн зогсож байна, 2009 оны 6 дугаар сар. Раматулэй анхны охиноо 12 настай байхдаа уламжлалт аргаар төрүүлсэн байна. Дараагийн удаад тэрээр бие давхар болохдоо тосгоноосоо 12 километр зайтай Рамсагийн эрүүл мэндийн төвд очиж төрөлтийн өмнөх үзлэгт хамрагдаж хүүхдээ төрүүлсэн байна. 2009 оны 3 дугаар сард түүний дөрөвдэх хүүхдийн төрөх цаг болж өвдөлт эхэлсэн байна. "Өвдөж эхэлсний дараа нөхрийн ах намайг мотоциклд сундлаад эрүүл мэндийн төв рүү явсан. Нөхөр маань бас мотоциклтой араас явсан юм. Гол дээр иртэл салчин байхгүй байлаа. Ингээд би голын эрэг дээр ганцаараа хүүхдээ төрүүлсэн. Маш хэцүү байсан." хэмээн тэр ярьсан юм.

ЗОРИЛТ 7: БАЙГАЛЬ ОРЧНЫ ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ

Зорилго 7.Г: 2020 он гэхэд ядуусын хорооллын 100 сая хүний амьдрах нөхцлийг мэдэгдэхүйц хэмжээгээр сайжруулсан байх.

Шалгуур үзүүлэлт:

7.10 Ядуусын хороололд амьдарч буй иргэдийн тоо

Саяхны НҮБ-ын Хүн амын сангийн судалгаагаанаас үзэхэд 2000 оноос хойш 227 сая хүний амьдрал сайжирч ядуусын хорооллоос нүүсэн байна. Энэ нь Мянганы Хөгжлийн Зорилтод төлөвлөснөөс даруй 2.2 дахин хүний амьдрал сайжирсан хэрэг болно.¹²⁰ Энэ нь сайхан сонсогдож байгаа хэдий ч нийт дүнгээрээ ядуусын хорооллын болон зөвшөөрөлгүй суурингуудын суугчдын тоо урьд өмнөхөөс нэмэгджээ. НҮБ-ын Хүн Амын Сангийн 2005 оны байдлаар хийсэн судалгаагаанаас үзэхэд хөгжингүй болон хөгжиж буй орнуудад нийтдээ нэг тэрбум гаруй хүн ядуусын хороололд амьдарч байна.¹²¹ Дан хөгжиж буй орнуудын байдлаас үзэхэд 2000 онд 767 сая хүн ядуусын хороололд амьдарч байсан бол 2010 он гэхэд энэ тоо 828 саяд хүрсэн байна.¹²² Энэ нь суурин (хотод) амьдарч буй гурван хүн тутмын нэг нь ЭЗНСЭОУП-ын 11.1-р¹²³ зүйлд заасан зохистой орон байраар хангагдах эрхээ эдэлж чадахгүй байна гэсэн үг мөн. 11.1-р зүйлд нэгдүгээрт, өөрсдийн эзэмшилтэй байх эрхийг нь хууль зүйн талаас хангах, хоёрдугаарт үйлчилгээ, материал, байр сууц болон дэд бүтцээр хангагдах, гуравдугаарт газар, дөрөвдүгээрт тав тух, тавдугаарт хямд өртөгтэй байх, зургаадугаарт ойр дөт байх, долоодугаарт соёл зан заншилд нь харшлахгүй байна гэж заасан. НҮБ-ын Хүн амын сангийн мониторингийн дүнгээс үзэхэд ядуусын хорооллын суугчдын байр сууц, ахуйг сайжруулах зорилт тун хангалтгүй хэрэгжилттэй байна. Үүнийг ядуусын суурингууд үер усны аюулд ойрхон байршилтай, газрын гулгалт болон байгалийн бусад гамшигт өртөмтгий, маш олноор суурьшсан, муу зохион байгуулагдсан, сууцны хүрэлцээ хангалтгүй байгаагаас олж харж болно.¹²⁴

ДЭЛХИЙН ТҮВШНИЙ ЗОРИЛТ

Улс орнууд олон улсын хуулийн дагуу ядуусын болон зөвшөөрөлгүй сууринд амьдарч буй иргэдийн ахуй нөхцлийг сайжруулж эрхийг нь хангах талаар дорвитой ажил хийх хэрэгтэй байна. Нөхцөл байдал маш хүнд байгаа нь цаг алдаж алгуурлалгүй яаралтай арга хэмжээ авахыг шаардаж байна.

Судалгаанаас үзэхэд 2020 он гэхэд ядуусын хорооллын суугчдын тоо 1.4 тэрбум болох төлөв харагдаж байна. Мянганы Хөгжлийн бусад зорилтод эрсдэлд буй хүмүүсийн тоог нэг дахин буюу 3/1 хувиар бууруулах зорилт тавигдсан бол олон улсын байгууллагууд ядуусын суурингийн суугчдын тоог ердөө 10¹²⁵ орчим хувиар бууруулах зорилт тавьсан. Мөн тодорхой бус “мэдэгдэхүйц өөрчлөлт гаргана” гэсэн зорилт тавиад чухам ямар өөрчлөлт авчрах талаар тодорхойгүй орхисон юм. Шалгуур үзүүлэлт нь мөн адил “хотын ядуу иргэдийн харьцааг бууруулах” гэж ойлгомжгүй тодорхойлогдсон нь нийт дүндээ ядуусын тоо өссөн байлаа ч энэ шалгуур биелэсэн мэт харагдахаар байгаа юм. Тавигдсан зорилт улс орнуудын хүлээх үүрэгтэй харьцуулахад тун ч хангалтгүй байна. Олон улсын хүний эрхийн хуулийн дагуу зохистой орон байраар хангагдах эрхийг хэрэгжүүлэхийн тулд нэн даруй шийдвэртэй, төлөвлөгөөтэй, тууштай арга хэмжээ авч хамгийн их орхигдсон, эмзэг хэсгийнхний эрх ашгийг нэн түрүүнд тавьж ажиллах шаардлагатай байна.

ӨМЧЛӨХ ЭРХИЙН ЗӨРЧИЛ

Мянганы Хөгжлийн Зорилтуудад улс орнуудын нэн чухал үүрэг болох иргэний өмчлөх эрхийн наад захын баталгааг хангах талаар тусгагдаагүй орхигдсон.¹²⁶ Энэ бол ядуусын суурингийн иргэдийг гарч болох хүний эрхийн зөрчлөөс (эдгээр зөрчил нь ядуурлыг улам л нэмэгдүүлэх аюултай) хамгаалах урьдач нөхцөл байсан билээ. Иргэний өмчлөх эрхийг баталгаажуулах нь хүмүүсийн амьдрал, ахуй нөхцлийг сайжруулах, нийгмийн үйлчилгээнээс хүртэх үр шимийг сайжруулах учиртай. Ядуусын болон зөвшөөрөлгүй суурингийн оршин суугчдад засгийн газрууд “хууль бус” гэсэн нэр зүүсэн нь эдгээр иргэдийн эрх ашиг зөрчигдөж, хүчээр нүүлгэн шилжүүлэлт зэрэг хүний эрхийг зөрчсөн үйл ажиллагаанд өртөх эрсдэлийг нь нэмэгдүүлж байна. Үүнээс болж ядуус болон зөвшөөрөлгүй суурьшсан иргэд байр сууцаа өмчлөх, бусдад түрээслүүлэхэд бэрхшээл гардаг байна. Хөгжиж буй орны ядуусын хорооллын иргэдийн 30-50 хувь нь өмчлөх эрхийн ямар ч баримт бичиггүй байдаг байна.¹²⁷

Ядуу амьдралтай хүмүүст хүчээр нүүлгэн шилжүүлэлт асар хүнд хохирол учруулж байна. Албадан нүүлгэлтээс болж тэд гэр орон, хөршүүдээ, хувийн эд зүйлсээ алдахаас гадна хамгийн хохиролтой нь урьд тогтоосон харилцаа холбоо, эрхэлж буй бизнесээ алдаж байна. Зимбабве улсад “Мурамбацивана” нэрийн дор маш өргөн хүрээнд явуулсан хүчээр нүүлгэн шилжүүлэлт, түүнийг дагалдсан олон тооны байр сууц нураасан, зөвшөөрөлгүй бизнесийг хаасан үйл ажиллагаанаас болж нийтдээ 32538 жижиг бизнесийг устгаж, 97614 (дийлэнхи нь эмэгтэйчүүд) хүний амьдралыг сүйтгэсэн байна.¹²⁸

Өмчлөх эрхийг нь хангаж өгөхгүй байгаагаас ядуусын хорооллын иргэд нийгмийн үйлчилгээ авч чадахгүйн зэрэгцээ хот төлөвлөлт, хөрөнгө төсөвлөх ажилд хамрагдаж чадахгүй эрхээ зөрчүүлсээр байна. Олон улс оронд ядуусын хорооллын иргэдийн усны хангамж, эрүүл ахуйн үйлчилгээг хязгаарлаж байгаа нь тэднийг цэвэр ус, эрүүл ахуйн гачигдалд оруулж байна. Гэтэл Мянганы Хөгжлийн Зорилтын хяналт мониторингид эдгээр амин чухал хэрэгцээт зүйлд анхаарал хандуулахгүй байсаар байна.

БОЕНГ КАК НУУР

“Бидний амьдралд маш их хамаатай болохоор нь бид хөгжлийн төлөвлөгөөтэй анхааралтай танилцсан. Харин энэ төлөвлөгөөндөө биднийг байхгүй мэтээр орхичихсон байсан.”

Пном Пений Боенг Какийн оршин суугчид, 2008 оны 2-р сар.¹²⁹

Пном Пений Боенг Как нуурын эрэгт амьдардаг жирийн иргэд нүүлгэн шилжүүлэлттэй тулгараад байна. 2008 оны 8 сарын 26-нд нуурыг хатаах ажил эхэлсэн байна. Суугчдад нь энэ талаар урьд нь юу ч мэдэгдээгүй байна. Эрх баригчид иргэдийн газар өмчлөх эрхийг зөрчин 1000 гаруй айлыг хүчээр нүүлгэн шилжүүлсэн байна. Хэрэв нуурын эргээр амьдардаг бүх хүнийг хүчээр нүүлгэн шилжүүлэх юм бол Камбожийн дайнаас хойш гарч буй хамгийн олон хүнийг хамарсан хүчээр нүүлгэн шилжүүлэлт болох болно. Хөөгдөх аюулд өртөөд байгаа ядуу амьдралтай иргэд тэднийг Пном Пенээс хөөж өөр газарт суулгана гэдгээс тун эмээж байна. Тэднийг нуурын эргээс хөөж хотоос зайдуу улам хүнд нөхцөлтэй (эрүүл ахуй, цахилгаан зэрэг үйлчилгээ хомс, хангалтгүй) газарт суурьшуулах аюул тулгараад байна.

Энэ бол Камбожийн засгийн газар Мянганы Хөгжлийн Зорилтын хүрээнд ядуурлыг бууруулах хийгээд хөгжлийн төлөө хийж явуулж буй ажиллагаандаа гаргаж буй зөрчил юм.¹³⁰

Ядуусын болон зөвшөөрөлгүй сууринд амьдарч буй иргэд бусад иргэдтэй харьцуулахад хууль зүйн хамгаалалт муу орчинд амьдарч байна. Кени улсад газрын эзэд Кенийн Нийтийн Эрүүл мэндийн хуулийг зөрчин зөвшөөрөлгүй сууринд байр сууц түрээслэн амьдарч хүмүүст эрүүл ахуйн болон бусад үйлчилгээг үзүүлэхгүй байсаар. Харин орон нутгийн эрх баригчид хууль бус суурингуудад орон сууц барьж ядуу хүмүүст түрээслүүлж буй газрын эздэд хууль ёсны шаардлага тавихгүй байгаа нь тэднийг өөгшүүлж байна.¹³¹

Дийлэнхи ядуусын хорооллууд нь хотын бүс дотор байрлаж буй хэдий ч хотын бусад иргэдийг бодоход эрүүл мэнд, боловсрол зэрэг нийгмийн үйлчилгээг тун муу авч байна. НҮБ-ын Хүн амын сан статистик мэдээллийг нягталж үзээд ядуусын хорооллын иргэдэд хотын иргэдийн давуу талууд ямар ч хүртээмжгүй байгааг тогтоосон байна.¹³² Ядуусын хорооллын суугчид хотын бусад иргэдийн бодоход эрүүл мэндийн халамж үйлчилгээ, боловсрол, ажил эрхлэлт, хүнсний илчлэг, нялхсын эрүүл мэндийн үзүүлэлтээр хол хаягдан зах хязгаар нутгийн иргэдтэй ижил төвшинд амьдарч байна.

Италийн Ром хотод амьдарч буй цыган иргэдийн хувьд засаг захиргаанаас олгодог нийгмийн халамжийн сууцнаас огт хүртэж чадахгүй байна.¹³³ Нийгмийн халамжийн байрыг олгох шалгууртаа цыган иргэдийг шууд бусаар ялгаварлан гадуурхах хандлагатай шалгуур тавьсны нэг жишээ нь нийгмийн халамжийн сууцыг хувийн байрнаасаа гарсан хүнд олгоно гэсэн заалт мөн. Үүнээс болж орон нутгийн эрх баригчдын мэдлийн хоргодох баазаас гарсан цыган иргэд ч нийгмийн халамжийн сууцанд орж чадахгүй байсаар байна. Энэ байдал бол Италийн засгийн газрын нийгмийн халамжийн сууцны хөтөлбөрт нийгмийн хамгийн эмзэг хэсгийнхэнийг хамруулах зорилготой нь харшилж байна.

Иргэний өмчлөх эрхийг баталгаажуулах нь хүний нийгмийн үйлчилгээ хүртэх, тэдэнд тулгарч болох эрсдэлийг багасгах өндөр ач холбогдолтой. Харин одоогийн байдлаар өмчлөх эрхийг баталгаажуулах асуудал (өмчлөх эрх нь баталгаажсан сууцны харьцаа) Мянганы Хөгжлийн Зорилтын үнэлгээний шалгуураас хамаагүй доор байна.¹³⁴

Ядуус болон зөвшөөрөлгүй суурьшсан иргэдийн хууль бус гэсэн статус нь тэдний хууль сахиулах байгууллагаас тусламж авах бололцоог нь үгүй хийж байна. Үүнээс болж тэд цагдаагийн байгууллагаар хамгаалуулах боломжгүй болдог. Мөн цагдаагийн байгууллага, гэмт хэргийн бүлэглэлүүдийн зөрчлийн¹³⁵ хохирогч болох нь олон байгаа юм. Бразил, Ямайкийн ядуусын хорооллуудад хууль эрх зүй, төрийн ямар ч нөлөөгүй газар олон байна. Үүнээс болж эдгээр газруудад гэмт бүлэглэл, хар тамхи наймаалагчид хяналтаа тогтоосон учир оршин суугчдад нь ямар ч хамгаалалт байхгүй байна. Гэмт хэргийн бүлэглэлүүд хөл хорио тогтоосон, тээврийн үйлчилгээ, боловсрол, эрүүл мэнд, ажил эрхлэх тал дээр хяналт тавьж буй газар ч олон байна.¹³⁶

Ядуусын хорооллын суугчид их бага ямар нэг хэмжээгээр байнга гэмт хэрэгт өртөж хохирч байна. Дэлхийн 6 хотод хийсэн судалгаагаар ядуусын хороололд эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгдэж буй хүчирхийлэлд ямар ч хяналт байхгүй байгааг тогтоосон байна.¹³⁷ Эмэгтэйчүүд гэр орондоо төдийгүй гэрээсээ гадуур хүчирхийлэлд өртдөг аж. Дийлэнхи тохиолдолд ажилдаа очих, тарах замдаа, нийтийн бие засах газар очих замдаа болон олон нийтийн байранд хүчирхийлэлд өртөж байна. Ядуусын хорооллын оршин суугчдыг дорд үзсэн хандлага, мөн ойр хавьд нь хууль сахиулах байгууллага байдаггүй зэргээс болж хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд ихэнхидээ гомдол гаргаж чаддаггүй байна.¹³⁸

ИДЭВХИТЭЙ ОРОЛЦОО

МХЗ-ын зорилт ядуусын хорооллыг сайжруулах төлөвлөгөө, явуулах үйл ажиллагаанд хүмүүсийг оролцуулах талаар төдийлөн тусгагдаагүй. Найробид хэрэгжүүлж буй ядуусын хорооллын нөхцлийг сайжруулах хөтөлбөрт арга хэмжээний хүрээнд иргэдтэй зөвлөлдөж, тэдэнд мэдээлэл хүргэх ажил огт хийгдээгүй байна. Үүнээс болж ядуусын хороололд барьж буй сууцны үнэ, орчин нөхцлийн талаар маргаантай олон асуудлууд урган гарч ирсэн байна. 2006 онд тус улсын засгийн газар ядуусын хорооллын сайжруулж буй нэг хэсгийг “баталгаат өмчлөлийн бүс” болгон зарласан бөгөөд мөн “хамгийн тохиромжтой өмчлөлийн системийг суугчдад, барилга эзэмшигчид болон хамтран хариуцагчдад бүрдүүлэн өгч ... суугчдад давуу эрх олгон, хүчээр нүүлгэн шилжүүлэхгүй” байх амлалт өгсөн.¹³⁹ Гэсэн хэдий энэ амлалт бүрэн хэрэгжихгүй байгаа учир суугчид төслийн хэрэгжилтээс үүдэн нүүлгэн шилжүүлэх вий гэдгээс маш их санаа зовж байна.¹⁴⁰

ХҮНИЙ ЭРХИЙН ХЭМ ХЭМЖЭЭГ ХАНГАХ НЬ

Олон улсын хууль эрх зүйн дагуу Мянганы Хөгжлийн Зорилтын 7.Г зорилтыг биелүүлэхийн тулд засгийн газрууд:

- Ядуусын хорооллын суугчдыг нүүлгэн шилжүүлэхээс хамгаалан тэдний шаардлагатай орон байраар хангагдах эрхийг нь эдлүүлэх. Өмчлөх эрхийг хууль эрх зүй, бодлого төлөвлөгөөндөө бүрэн хангасан тогтолцоог бий болгох нь иргэдийн ахуй нөхцлийг муутгахаас сэргийлэх, иргэдийн тогтвортой амьдралын баталгааг хангах нөлөөтэй. Энэ нь ядуусын хорооллын суугчдын орон байрны нөхцлийг сайжруулах талаар засгийн газар болон олон нийтийн хамтран явуулж буй ажлын үр дүнг мөн адил сайжруулна. Хуулийн баталгаа гаргаж бодлого үйл ажиллагаандаа үүнийгээ дагаж мөрдөх, Мянганы Хөгжлийн Зорилтын хүрээнд явуулж буй үйл ажиллагаандаа хүний эрхийн зөрчил (ядуусын хорооллыг устгах гэдгээр хүмүүсийг хүчээр нүүлгэх зэрэг зөрчлүүд энд орно) гаргахаас сэргийлэх.
- Газрын эзэд, хувийн өмчлөгчид хүмүүсийг хүчээр нүүлгэхээс хамгаалан иргэдийн шаардлагатай орон байраар хангагдах эрхийг нь бүрэн дүүрэн баталгаажуулах. Байр түрээслүүлэгч, өмчлөгчид төлбөрөө үндэслэлгүйгээр нэмэх зэргээс хамгаалах хууль зүйн үндсийг бүрдүүлэх.

- Нийгмийн хамгийн эмзэг хэсгийнхний эрх ашгийг нэн тэргүүнд тавьж ажиллах. Хүний тулд иргэдийн оролцоог хангаж, шаардлагатай орон байраар хангах, ядуусын хорооллын нөхцлийг сайжруулах, нийгмийн халамжийн сууц барьж байгуулах талаар бодлого боловсруулж ажиллах шаардлагатай байгаа бөгөөд ингэж чадвал хүний шаардлагатай орон байраар хангагдах эрх хэрэгжих болно.
- Аливаа бодлого, хууль эрх зүйн акт, хөтөлбөртөө ялгаварлан гадуурхахгүй байхыг хангах. Ядуусын хорооллын нөхцлийг сайжруулах болон байр сууцаар хангах хөтөлбөр үйл ажиллагаандаа эмэгтэйчүүдийг гэр бүлтэй эсэх болон бусад статусаар нь ялгаварлан гадуурхах (мөн эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах агуулгатай уламжлалт зан заншил болон өмч хөрөнгийн хууль зэрэг мөн энд орно) шинжтэй зүйлсийг арилгах.
- Ядуусын хорооллын суугчдад хяналт тавихад (хууль эрх зүйн акт болон бодлого хөтөлбөрт хяналт тавих механизм үүнд орно) оролцох боломж гаргаж өгөх. Энэ нь ядуусын хорооллын суугчдад тэдэнд тулгарч буй гадуурхах, орхигдуулах зэрэгт нийтийн анхаарлыг хандуулах болон Мянганы Хөгжлийн Зорилтын хүрээнд хийгдэж буй ажлуудад өөрсдийн эрх ашгийг хамгаалах бололцоо олгоно.

4 ДҮГЭЭР БҮЛЭГ: ХҮНИЙ ЭРХ БОЛ ХӨГЖЛИЙН ҮНДЭС

Олон улсын хүний эрхийн хэм хэмжээ нь улс орнууд Мянганы Хөгжлийн Зорилтоо биелүүлэх бодлого үйл ажиллагаа боловсруулахад нэгэн чухал үндэс суурь нь болж өгнө. Мөн улс орнуудын анхаарлыг хамгийн эмзэг, орхигдсон хүмүүс, ялгаварлан гадуурхалтай тэмцэх, хүмүүсийн оролцоог үр дүнтэй байлгахад хандуулж үйл ажиллагаанд нь тусгах маш чухал үүрэгтэй. Хүний эрхийн үзэл санаа нь бодлого боловсруулагчдад чухам юунд анхаарал тавих хэрэгтэйг сануулж байдаг.

Мянганы Хөгжлийн Зорилтын нэг дутагдал бол улс орнуудаас хүний эрхийн хэм хэмжээг үйл ажиллагаандаа (улс орнуудын МХЗ-ын хүрээнд явуулж буй бодлого, үйл ажиллагаа зэрэг үүнд орно) тусгах шаардлага огт тавиагүйд байгаа юм. Жишээ болгоход “Хөгжлийн төлөө дэлхий нийтийн түншлэлийг хөгжүүлэх” зорилтод хөгжингүй орнуудыг Мянганы Хөгжлийн Зорилтыг хэрэгжүүлэхэд санхүүгийн туслалцаа, худалдаа, өрийн бодлогын хүрээнд тусламж дэмжлэг үзүүлэх талаар тусгасан хэдий ч хүний эрхийг стандартыг дагаж мөрдөх талаар орхигдуулсан. Монгол зэрэг цөөхөн хэдэн орон өөрийн Мянганы Хөгжлийн Зорилтууддаа хүний эрхийн талаар тусгасан. Монгол улсын хувьд 9 дэх зорилтоо хүний эрх, ардчиллыг бэхжүүлэх асуудалд зориулсан. Дийлэнхи улс орнууд Мянганы Хөгжлийн Зорилтын тайландаа хүний эрхийн асуудлыг нэг бол орхигдуулж, эсвэл бэлэгдлийн төдий дурдаад өнгөрч байна.¹⁴¹

Улс орнууд хийгээд олон улсын байгууллагууд өөрсдийн явуулж буй ажлуудыг хүний эрхийн үүднээс үнэлж цэгнэх, хүний эрхийн хэм хэмжээнд нийцтэй байлгах механизмыг бүрдүүлэх шаардлагатай байгаа юм. Ингэж чадвал Мянганы Хөгжлийн Зорилтод саад болж буй ялгаварлан гадуурхах шинжтэй хууль журмууд, эмэгтэйчүүдийн хүчирхийллээс хамгаалах чадамжгүй систем, ядуусын хорооллын суугчдын талаар явуулж буй үр ашиггүй бодлого зэргийг тодорхой болгон, хууль журам болон бодлого үйл ажиллагаанд ямар өөрчлөлт шаардлагатай байгааг ил гаргаж чадна. Мөн улс орнуудын МХЗ-ын хүрээнд явуулж буй үйл ажиллагаанууд нь зорилго чиглэлээсээ хазайх, энэ нь цаашлаад хүний эрхийн зөрчилд хүргэхээс сэргийлэх ач холбогдолтой юм.

ЗАСГИЙН ГАЗРУУДАД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

ХАРИУЦЛАГЫГ САЙЖРУУЛАХ

Хүний эрхийг хүндэтгэн хамгаалж, хангах талаар үндэсний болон олон улсын хариуцлагын механизм шаардлагатай байна. Түүнчлэн хүний эрхийн зөрчил, хүчирхийллийн хохирлыг арилгах үр дүнтэй механизм шаардлагатай байна.

Үүнийг хэрэгжүүлэхийн тулд Засгийн Газрууд:

- Иргэдийн эрхээ хуулиар хамгаалуулах бололцоог ханган, эрхээ зөрчүүлж хохирсон иргэдийн хохирлыг барагдуулах болон хууль эрх зүйд буй дутагдал (хүний эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хэрэгжлүүлэх тал дээр гарч буй дутагдлууд) зэрэгт анхааран ажиллах хэрэгтэй байна.

- Ядуу амьдралтай хүмүүсийн хуулийн байгууллагад хандах, тэдний хохирлыг барагдуулахад тохиолдож буй саад бэрхшээлүүдийг арилгах хэрэгтэй.

- Хүний эрхийн хяналтын байгууллагыг бий болгож үр дүнтэй ажиллуулах шаардлагатай.

- Хууль тогтоох байгууллагын зүгээс Мянганы Хөгжлийн Зорилтын хүрээнд хийгдэж буй ажлууд нь хүний эрхийг хэр хангаж буй талаар хийх хяналтыг эрчимжүүлэх шаардлагатай.

Олон улсын түвшинд Мянганы Хөгжлийн Зорилтын хэрэгжилтийг үнэлэх талаар ахиц гаргахын тулд улс орнууд:

- Хүний эрхийн дээд комиссоорын газар, ХЭТБЭДХ зэрэг хүний эрхийн асуудал эрхэлсэн байгууллагад үндэсний болон олон улсын түвшинд явуулж буй ажлаа системтэйгээр тайлагнах хэрэгтэй байна.

- Мөн ХЭТБЭДХ-ын хүрээнд бусад улс орнуудад хандаж хүний эрхийг хангах талаар МХЗ-ын үйл ажиллагаандаа тусгах асуудлаар саналаа илэрхийлж байх хэрэгтэй.

- Хүний эрхийн олон улсын баримт бичиг, хэм хэмжээг хэрхэн даган мөрдөж байгааг шалгаж байх шаардлагатай байна.

ХҮНИЙ ЭРХИЙН ХЭМ ХЭМЖЭЭНД НИЙЦТЭЙ БАЙДЛЫГ ХАНГАХ

Засгийн газрууд тэдний Мянганы Хөгжлийн Зорилтын хүрээнд явуулж буй бүхий л бодлого, үйл ажиллагаа, хууль нь хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэхийг хянах хэрэгтэй байна.

Үүний тулд:

- Мянганы Хөгжлийн Зорилт, түүнтэй холбоотой ажлууд нь хүний эрхийн хэм хэмжээг хангаж буй эсэхэд хяналт тавих институт байгуулах хэрэгтэй.

- Хууль эрх зүй, бодлого хөтөлбөр, үйл ажиллагаанд алдаа дутагдал байвал энэхүү дутагдалаа хүний эрхийн хэм хэмжээнд нийцүүлэх, өөрчлөн сайжруулж байх хэрэгтэй байна.

- Засгийн газрын харьяа байгууллагууд, хууль хяналтын байгууллагуудын зүгээс хүний эрхийн хэм хэмжээг ханган ажиллах чиг үүргээ чанд биелүүлэн ажиллах хэрэгтэй.

- Хяналтын ажлыг сайжруулж олон улсын хүний эрхийн хяналт, мониторингийн байгууллагуудаас гаргасан зөвлөмжийг ажилдаа тусгаж байх хэрэгтэй.

НИЙГМИЙН ХАМГИЙН ЭМЗЭГ БҮЛГИЙНХНИЙГ ХАМРУУЛАХ

Улс орнууд Мянганы Хөгжлийн Зорилтууддаа бүх хүмүүсийг хамруулахын тулд ялгаварлан гадуурхах, хүйсийн тэгш бус байдалд анхаарлаа хандуулж, хамгийн боломж чадавхи муу хүмүүсийн эрх ашгийг нэн тэргүүнд тавин ажиллах хэрэгтэй байна.

Үүний тулд:

- Ямар хүмүүс ялгаварлан гадуурхалтанд өртөн, саад бэрхшээлтэй тулгарч байгааг нарийвчлан тогтоон энэ бүх саад бэрхшээлүүдийг устган, хамгийн эмзэг бүлгийн хүмүүсийн амьдралыг сайжруулахад үйл ажиллагаагаа чиглүүлэх,
- Бүх хэлбэрийн ялгаварлан гадуурхалтыг устгах үр нөлөөтэй арга хэмжээ авч бодлого төлөвлөгөө, хууль эрх зүй, үйл ажиллагаандаа хамгийн эмзэг, чадавхи боломж тааруу хүмүүсийн эрх ашгийг нэн тэргүүнд тавьж ажиллах,
- Тусгайлан хөтөлбөрт үйл ажиллагаа, явуулж буй бодлогод хамгийн ихээр холбогдож буй хүмүүстэй идэвхитэй зөвлөлдөн үйл ажиллагаагаа явуулах,
- Үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл олж авах, эвлэлдэн нэгдэх эрхийг хамгаалахын зэрэгцээ Мянганы Хөгжлийн Зорилтын үйл ажиллагаанд оролцох боломжийг нь ханган өгөх,
- Хүний эрхийн төлөө тэмцэгчдийг хамгаалж, тэдэнд аливаа хориг саадаас ангид байж, үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх боломжоор хангах хэрэгтэй байна.

ОЛОН УЛСЫН ХӨГЖЛИЙН БОЛОН САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГАД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Ядуурлыг бууруулан Мянганы Хөгжлийн Зорилтууддаа биелүүлэхэд санхүүгийн болон техникийн туслалцаа чухал хувь нэмэр оруулна. Олон улсын хамтын ажиллагаа, тусламж дэмжлэг нь хүний эрхийг дэлхий даяар түгээх талаар НҮБ-ын тунхаглал болон бусад баримт бичгүүдэд тусгагдсан.¹⁴² Эдийн засаг, нийгэм соёлын эрхийг бүрэн хэрэгжүүлэхэд гэрээ хэлэлцээрүүдийн хяналтыг хэрэгжүүлэх байгууллага ямар үүрэг гүйцэтгэх талаар ч мөн адил тодорхой тусгагдсан. Засгийн газрууд хамтран ажиллахдаа ямар үүрэг хүлээх, үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд ямар зүйлс шаардлагатай байгаа талаар ч тодорхой болсон.¹⁴³

НҮБ-ын хэд хэдэн байгууллага хөгжлийн хамтын ажиллагаандаа хүний эрхэд суурилсан арга замыг сонгон хэрэгжүүлж байна. Хүний эрхэд суурилсан хөгжлийн хамтын ажиллагааны¹⁴⁴ талаархи НҮБ-ын баримт бичгүүдэд:

1. Хөгжлийн хамтын ажиллагааны бүх хөтөлбөр ХЭТТ болон бусад баримт бичигт заасны дагуу хүний эрхийг бодитоор эдлүүлэхэд чиглэх ёстой.
2. ХЭТТ болон бусад олон улсын хүний эрхийн баримт бичигт тодорхойлсон хүний эрхийн хэм хэмжээг олон улсын хөгжлийн хамтын ажиллагааны бүх үе шат, бүх секторт ханган ажиллах ёстой.
3. Хөгжлийн хамтын ажиллагаа нь эрх мэдэлтнүүдийг үүргээ сахих, ЭРХ ЭДЛЭГЧДИЙН эрхээ эдлэх баталгааг хангах ёстой.

Гэхдээ энэ бүхэн тийм ч хангалттай хэрэгжихгүй байгааг хэлэх ёстой.

“Хөгжиж буй орнууд болон донор орнууд тэдний хөгжлийн бодлого, хөтөлбөрүүд нь жендэрийн тэгш байдал, хүний эрх, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүрээлэн буй орчны тогтвортой байдлыг төлөвлөлт болон хэрэгжилтийн бүхий л шатанд хангах үүрэгтэй.”

Аккрагийн тунхаглал, 2008 он.¹⁴⁵

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын (OECD-DAC) Хөгжлийн туслалцааны Хорооноос хүний эрхийг хөгжлийн бодлого, хэрэгжилтэнд хэрэгжүүлэх асуудлаар дэмжлэг үзүүлж байгаа. Тус хорооны Үйл ажиллагааны бодлогын баримт бичигт¹⁴⁶ донор байгууллагуудыг хүний эрхийн бодлого, хөтөлбөртөө 10 зарчмыг нэвтрүүлэхийг хүсэж уриалга гаргасан. Үүнд донорын бодлого, хөтөлбөрүүд нь хэрхэн ажиллах болон ялгаварлан гадуурхахгүй байхад юу шаардлагатайг заасан юм.¹⁴⁷ Мөн хүний эрхийн талаар хүлээсэн үүрэг болон хөгжлийн асуудалд барьж буй хамгийн чухал асуудлууд донор болон хамтран ажиллаж буй засгийн газруудын хамтын ажиллагаанд нэн тэргүүнд тавигдах шаардлагатай. Хөгжлийн туслалцаа мөн засгийн газруудыг олон улсын хүний эрхийн хуулийн дагуу авсан үүрэг амлалтаа хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх хэрэгтэй байна.¹⁴⁸

ХӨГЖЛИЙН ТУСЛАЛЦААНД ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

Мянганы Хөгжлийн Зорилтыг хэрэгжүүлэхэд тусламж дэмжлэг авах хэрэгцээ гарсан бол засгийн газрууд уг хөгжлийн туслалцаа нь тэдний хүний эрхийн талаар хүлээсэн үүрэг, зорилтонд нь нийцэж байгааг батлах шаардлагатай. Хүний нийгэм, эдийн засаг, соёлын эрхийн наад захын хэм хэмжээг биелүүлэх үүднээс олон улсын туслалцаа авах шаардлагатай байгаа улс орнууд энэхүү туслалцаа нь ялгаварлан гадуурхахгүй байж, хүйсийн тэгш байдлыг дэмжиж, хамгийн эмзэг нийгмийн бүлгийн эрх ашгийг нэн тэргүүнд дээдлэн ажиллах болно гэсэн баталгаа гаргаж өгөх шаардлагатай. Үүний зэрэгцээ хөгжлийн тусламжийн зарцуулалтыг ил тод байлган, хариуцлагатай зарцуулах болон орон нутгийн иргэд, иргэний байгууллагууд, парламент болон бусад байгууллагын зүгээс явуулж буй үйл ажиллагаанд үр ашигтайгаар оролцох, донорын тусламж дэмжлэгийн зарцуулалтанд хяналт тавих боломжийг бүрдүүлж өгнө.

Эмнести Интернэшнл хөгжлийн болон олон улсын санхүүгийн байгууллагуудад хандан тэдний үзүүлж буй тусламж нь хүний эрхийн хэм хэмжээнд нийцтэй байх шаардлагын үүднээс:

- Донор байгууллагын өгч буй техникийн болон санхүүгийн тусламж нь хүний эдийн засаг, нийгэм соёлын эрхийн наад захын түвшинг хангахад чиглэгдсэн байх.
- Хоёр талын хүлээх хариуцлагыг сайжруулахын тулд олгож буй тусламж дэмжлэг нь хүний эрхийн үндсэн зарчмууд, тогтоосон хэм хэмжээг хангахад чиглэсэн байвал зохино. Мөн донор байгууллагууд хийгээд тусламж дэмжлэг авч буй засгийн газрууд бодлого боловсруулах болон ядуурлыг бууруулах стратеги боловсруулах, тусламж дэмжлэгийг ямар асуудалд эхлэн зарцуулах талаар шийдвэр гаргахдаа хүний эрхийн хэм хэмжээг хангах асуудлыг удирдлага болгон ажиллах.

- Хөгжлийн тусламж нь хүний эрхэд нийцтэй байгаа эсэхийг хянах механизм бүрдүүлж хариуцлагын асуудлыг тусгаж өгөх. Үүний тулд донор байгууллагын хяналтыг зохистой хэмжээнд бий болгох, бодлогын түвшинд хүний эрхийн хэм хэмжээг хангах хийгээд олгож буй тусламж дэмжлэг хүний эрхийн асуудлуудад ямар нөлөө үзүүлж байгааг НҮБ (UPR үүнд орно) болон бусад олон улсын хүний эрхийн байгууллагад тайлагнаж байх.¹⁴⁹
- Хөгжлийн бодлогодоо хүний эрхийн тусган үүнийгээ олгож буй тусламж дэмжлэгтээ ч хадгалах. Ингэж чадвал донор байгууллагын тусламж хүний эрхэд харш зүйлд зарцуулагдахаас сэргийлэх.
- Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн наад зах хэм хэмжээг бодитоор бий болгоход анхаарлаа хандуулж, хамгийн ядуу, эмзэг бүлгийн эрх ашгийг нэн тэргүүнд тавин ажиллахын зэрэгцээ донорын өгч буй тусламж эдгээр хүмүүст зориулагдаж буй эсэхэд бодитой хяналт тавьж ажиллах тусламж, хөтөлбөрүүдийг ялгаварлан гадуурхалт, нэн ялангуяа хүйсээр ялгаварлан гадуурхаж буйг устгахад чиглүүлэх. Хандивлагчид тусламж авч буй улс орнуудтайгаа хамтран хүйсээр ялгаварлан гадуурхалтын ямар хэлбэр байгааг тогтоон тусламж дэмжлэгээ ялгаварлан гадуурхалтыг устгахад зориулах.
- Хөгжлийн тусламжийн зарцуулалтанд хүн амын бүх бүлэг (нийгмийн хамгийн эмзэг бүлэг, иргэний нийгмийн байгууллага, хууль тогтоох байгууллагын төлөөлөгчид хийгээд үндэсний хүний эрхийн байгууллагууд) идэвхитэй оролцохыг дэмжин, боломжийг бүрдүүлж өгөх.
- Хөгжлийн туслалцааны зорилго, үндэслэл, хэмжээ, нөхцөл хийгээд хэрхэн зарцуулах, хяналт тавих, үр дүнг нь үнэлэх зэрэг шаардлагатай мэдээллийг ил тод, олон нийтэд нээлттэй байлгах шаардлагатай байна.

